



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМАНД ХЭРЭГЖИХ
“НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР-5435528/

ХЯНАСАН:

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН,
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН
ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

П.ШИНЭЦЭЦЭГ

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
САЛБАРЫН ЗАХИРАЛ

Л.ДОРЖСҮРЭН

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА

Б.БАТСАЙХАН

ГАРЧИГ

1.	ОРШИЛ	1
2.	ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
2.1	Төслийн зорилго, хүчин чадал.....	2
2.2	Төслийн ерөнхий төлөвлөлт	3
2.3	Ерөнхий гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгч байгууллагуудын мэдээлэл	4
3.	ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
3.1	Уур амьсгал	4
3.2	Геоморфологи.....	4
3.3	Хөрс	5
3.4	Ургамлан бүрхэвч	5
3.5	Нийгэм, эдийн засаг.....	5
3.6	Төслийн талбайн байршил	6
4.	ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	6
4.1	Эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн матриц	7
4.2	Газрын гадарга, хэвлий	8
4.3	Агаарын чанар	8
4.4	Уур амьсгал	9
4.5	Гадаргын болон газрын доорх ус	9
4.6	Ургамлан нөмрөг.....	9
4.7	Амьтны аймаг	9
4.8	Тусгай хамгаалалттай газар нутаг	9
4.9	Дуу шуугиан.....	9
4.10	Нийгэм, эдийн засаг.....	9
4.11	Түүх, соёлын дурсгалт зүйлс	9
4.12	Хог хаягдлын менежмент	10
5.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	10
6.	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	10
6.1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр.....	10
6.1.1	Барилгын ажлын үед үүсэх тоосжилтыг дарахын тулд зам, талбайг услах	11
6.1.2	Цэвэрлэх байгууламжтай ААН-д гэрээгээрээ шингэн хаягдлаа нийлүүлэх	11
6.1.3	Хаягдлын овоолгын усалгаа хийж дагтаршуулах	11
6.2	Газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	12
6.2.1	Өнгөн хөрсний овоолгыг 2 жил ашиглахгүй бол стандартын дагуу хадгалах	12
6.2.2	Тусгай зөвшөөрөл бүхий ААНБ-аас ТТАМ-ийг ашиглах, гэрээ, бичиг баримтын бүрдлийг хангах	13
6.2.3	Замын маршрутын батлуулж зөвхөн батлагдсан маршрутаар зорчих	13
6.2.4	Эвдрэлд өртсөн газрыг байгалийн унаган төрхөнд нь дөхүүлэн хэлбэршүүлэх.....	14
6.3	Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	15
6.3.1	Бохир ус цэвэрлэх байгууламж байгуулах	15

6.3.2	Хог хаягдлын түр цэгт тогтмол хяналт тавьж ажиллах	16
6.3.3	Шимт хөрсний овоолгыг нимгэн материалаар хучиж хадгалах	16
6.3.4	Химийн бодисын сав баглаа боодлын хаягдлын талбай байгуулах	16
6.4	Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр.....	17
6.4.1	Ус ашиглуулах дүгнэлт, гэрээ, зөвшөөрөл	17
6.4.2	Худагт бохирдол алдагдахаас сэргийлэх, холбогдох шаардлага, стандартын дагуу худгийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих.....	19
6.5	Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	20
6.5.1	Кемп болон НБҮ-ийн ойр орчимд харагдаж буй амьтдыг тэмдэглэх	20
6.5.2	Хөнжлийн нуруунд амьтдын нүүдлийн трассуудыг тогтоох, камержуулах.....	21
7.	ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	22
7.1	Ногоон байгууламж нэмэгдүүлэх зорилгоор модлог ургамал тариалах	22
8.	ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	23
8.1	Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр	23
8.1.1	Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах	24
8.1.2	Гамшгийн эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	24
8.1.3	Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	25
8.1.4	Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах	26
8.2	Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр	27
8.2.1	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих.....	27
9.	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	28
9.1	Ахуйн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний чиглэлээр	28
9.1.1	Ахуйн гаралтай хог хаягдлыг ангилан ялгаж дахин ашиглах, зайлуулах арга хэмжээнүүдийг тодорхойлох.....	28
9.1.2	Дотоод, гадаад орчны хог цуглуулах савны стандартыг сайжруулах	30
9.2	Үйлдвэрлэлийн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний чиглэлээр	31
9.2.1	Үйлдвэрлэлийн гаралтай хаягдлыг ил задгай хаяхгүй байх, зориулалтын битүү саванд ангилан ялгаж, хадгалах дахин ашиглах болон үйлдвэрлэгчид нийлүүлэх	31
9.3	Аюултай хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний чиглэлээр	33
9.3.1	Аюултай хог хаягдлын үүсгэгч болон аюултай хог хаягдлыг цуглуулах, хадгалах үйл ажиллагааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж, бүртгэлийн дугаар тусгай зөвшөөрөл авах	35
9.3.2	Тусгай зөвшөөрөлтэй ААНБ-тай хог хаягдал нийлүүлэх гэрээг байгуулах	36
9.3.3	Химийн хорт болон аюултай бодис ашиглах тусгай зөвшөөрөл авах	38
10.	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	39
10.1	Агаарын чанарын хяналт шинжилгээ.....	39
10.1.1	Гадаад орчны PM2.5, PM10 болон нийт тоосны хэмжилт.....	39
10.1.2	Хийн төлөвт агаар бохирдуулагчийн шинжилгээ	41
10.1.3	Дуу чимээний хяналт	42
10.2	Хөрсөн бүрхэвчийн хяналт, шинжилгээ	43

10.2.1	Хөрсөн дэх хүнд металлын агууламж.....	43
10.2.2	Агрохими.....	44
10.2.3	Нянгийн бохирдол.....	44
10.3	Усан орчны хяналт шинжилгээ	45
10.3.1	Усны хими, физикийн ерөнхий шинжилгээ	45
10.3.2	Усны хүнд металлын шинжилгээ	47
10.3.3	Микробиологийн шинжилгээ	47
10.4	Ургамлан бүрхэвчийн хяналт, шинжилгээ	48
10.4.1	Ургамлын мониторинг	48
10.5	Амьтны аймгийн мониторинг	51
10.5.1	Амьтны мониторинг	51
11.	УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	54
11.1	Байгаль хамгаалах ажлын барьцаа хөрөнгө төвлөрүүлэх.....	55
11.2	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайланг ажлын хэсгээр дүгнүүлэх	55
11.3	Жил бүрийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах.....	55
11.4	Байгаль орчны хууль, журам, стандартын хэрэгжилтийг хангах зорилгоор байгаль орчны дотоод хяналтыг хэрэгжүүлэх.....	56
12.	НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	57
12.1	Сумын иргэдэд БОМТ-н биелэлт танилцуулах.....	57
12.2	Нөлөөллийн бүсийн иргэд, сумын удирдлага, мэргэжилтэнүүдэд үйл ажиллагааг танилцуулах	58
13.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	59
14.	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР.....	60
15.	ХАВСРАЛТ	68

1. ОРШИЛ

Монгол Улсын Их Хурлаас 2015 онд баталсан “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”, Улсын Их Хурлын 2010 оны “Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай” 39 дүгээр тогтоол, 2018 оны “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 73 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газраас 2019 онд баталсан “Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөр”, мөн Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас 2019 онд баталсан “Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 41 тоот тогтоолоор батлагдсан 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Гүйцэтгэх захирлын 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/455 тоот тушаалаар байгуулагдсан “Нүүрс баяжуулах үйлдвэр”-ийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд тулгуурлан Тавантолгойн ордыг түшиглэн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах нь шинэ, дэвшилтэт, өндөр технологи, дамжуулах, нутагшуулах, нэмүү өртөг шингэсэн, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлээд зогсохгүй уул уурхай, зам тээвэр, усан хангамж, байгаль орчин зэрэг олон салбарыг хамарсан цогц бүтээн байгуулалтын төсөл юм.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг “Нүүрс баяжуулах үйлдвэр” –ийн батлагдсан ТЭЗҮ-ийн хүрээнд БОАЖЯ-ны 2022 оны 02-р сарын 28 өдрийн 13/1034 дугаар бүхий ерөнхий үнэлгээний дүгнэлтэд үндэслэн БОНХЯ-ны (хуучин нэрээр) 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, БОНХС-ын (хуучин нэрээр) 2014 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн А-05 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2012 оны А-50/378/565 дугаар тушаалаар батлагдсан “Химийн хорт болон аюултай бодисын эрсдэлийн үнэлгээ хийх журам”, “Химийн хорт болон аюултай бодисын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу боловсруулав.

БОННУ-ний ажлын үр дүнд үйлдвэрийн барилга байгууламж барих үеийн болон үйлдвэрийн ашиглалтын үйл ажиллагааны үе дэх байгаль орчин, нийгэм, эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоон үнэлсэн бөгөөд сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, улмаар хамгийн бага түвшинд хүртэл бууруулах, арилгахад чиглэсэн арга хэмжээний зөвлөмж, арга зүйг Монгол улсын стандарт, норм нормативд заасан шаардлагын дагуу тусгаж өгөв.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаал болон бусад Монгол улсын хууль, журам, тогтоолын шаардлагад нийцүүлсэн бөгөөд компанийн 2021-2025 оны стратеги төлөвлөгөөнд байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг төлөвлөн тусгасан.

Компани ISO 14001:2016 байгаль орчны удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээр байгаль орчны асуудлуудыг албан ёсоор тодорхойлж тэдгээрийг шийдвэрлэх шат дараатай алхмуудыг бодлогын баримт бичигт тусгасан. Стандартын хүрээнд тоосжилт бууруулахад ашиглах усны хэмжээг бууруулах, үйлдвэрт ашиглах гадаргын ус болон газар доорх усны харьцааг нэмэгдүүлэх, биологийн задралд ордог бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх болон хог хаягдлын дахин боловсруулалтыг сайжруулах замаар байгальд хаях хог хаягдлын хэмжээг бууруулах, хүрээлэн буй орчинд учруулж байгаа сөрөг нөлөөллийг ялангуяа агаар бохирдуулагчийг хянах тогтолцоог олон улсын түвшинд хүргэх, олон талын хэлэлцүүлэгт үндэслэсэн хаалтын бодлогыг бий болгох, хүлэмжийн хийн ялгаралыг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зэрэг гол асуудлуудыг байгаль орчны гол шалгууруудаар тодорхойлсон.

Тус төлөвлөгөө Тавантолгой орд газрын Нүүрс баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд хамаарахын хувьд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн туслан гүйцэтгэгч компаниудад мөрдөгдөнө.

Эдгээр стандарт шаардлага, төлөвлөлт, хариуцлагын хүрээнд 2024 онд хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэв.

2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Төслийн зорилго, хүчин чадал

“Нүүрс Баяжуулах Үйлдвэр” төсөл нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2021-2026 оны Бизнес төлөвлөгөөний хүрээнд өртөг зардал бууруулах, өрсөлдөх чадвар нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх томоохон зорилт дэвшүүлж байгаа бөгөөд дээрх тогтоол шийдвэрийн дагуу үндэсний их бүтээн байгуулалтын эхлэлийг бий болгож, цаашид сайн чанарын нүүрсний “Тавантолгой” брэнд бүтээгдэхүүн бий болгон олон улсын зах зээлд голлох байр суурь эзлэн аюулгүй, тогтвортой, нээлттэй, хариуцлагатай уул уурхай, үйлдвэрлэл, технологийн цогцолбор паркийг хөгжүүлэх, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хүртээх, шинээр ажлын байр бий болгох, улс орны болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах гол зорилготой.

Стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний бүлэг ордын ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх болон “Эрдэнэс Тавантолгой” ХК -ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд коксжих чанар султай нүүрсийг сайн чанарын нүүрстэй хольж баяжуулах, чанарыг дундажлан экспортын шаардлага хангасан, орчин үеийн, дэвшилтэт техник, технологи бүхий “Нүүрс баяжуулах үйлдвэр”-ийг богино хугацаанд барьж байгуулах нөхцөлийг хангахад төслийн үндсэн зорилт оршино.

Нүүрс баяжуулах үйлдвэрийг жилд 30.0 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай байхаар хоёр үе шаттай барьж байгуулахаар төлөвлөсөн. Нүүрс баяжуулах үйлдвэр нь ижил хүчин чадалтай, хоорондоо хамааралгүй ажиллах боломжтой тус бүр 10.0 сая тонн хүчин чадалтай 3 модуль байх ба нэг модулийн үндсэн баяжуулах нь 5.0 сая тонн хүчин чадалтай бие даасан 2 шугамтай байна.

Нүүрс баяжуулах үйлдвэр (цаашид НБҮ гэх) нь тасралтгүй ажиллагаатайгаар долоо хоногийн 7 өдөр 12 цагаар 2 ээлжээр ажиллах бөгөөд баяжуулах үйлдвэр нь 7 хоногт 1 удаа төлөвлөгөөт зогсолт хийж, засвар үйлчилгээ явуулахаар төлөвлөсөн. НБҮ-ийг 2023 оны 6-р сараас ашиглалтад оруулахаар төлөвлөсөн бөгөөд эхний жилд 5.0 сая тонн, 2024-2025 онд 10.0 сая тонн нүүрс баяжуулна. 2026 оноос баяжуулах үйлдвэрийн 2 ба 3 дахь шугам ашиглалтад орсноор үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллахаар төлөвлөөд байна. НБҮ-ийн ажиллах горим, хүчин чадлыг тооцон Хүснэгт 1-д үзүүлэв.

“Нүүрс Баяжуулах Үйлдвэр” төслийн ерөнхий гүйцэтгэгчээр “Норинко Интернэйшнл Кооперэйшн” ХХК сонгогдон ажиллаж байна.

Хүснэгт № 1. Нүүрс баяжуулах үйлдвэрийн ажиллах горим, хүчин чадал

Үйл ажиллагааны хуваарь	Нэгж	Ашиглалтын жил			
		1	2	3	4
Жилийн календарь хоног	Хоног	183	365	365	365
Өдрийн хуанлийн цаг	Цаг	24	24	24	24
Жилийн хуанлийн цаг	Цаг	4,368	8,760	8,760	8,760
Засвар үйлчилгээний хоног /7 хоногт 1 удаа/	Хоног	26	52	52	52
Жилд бүрэн ажиллах хоног	Хоног	157	313	313	313
Жилд ажиллах боломжит цаг	Цаг	3,768	7,512	7,512	7,512
Цаг ашиглалтын коэффициент	%	0.9	0.9	0.9	0.9
Хоногт ажиллах бодит цаг	Цаг	21.6	21.6	21.6	21.6
Техникийн бэлэн байдлын коэф.	-	0.888	0.888	0.888	0.888
Жилд ажиллах бодит цаг	-	3,011	6,003	6,003	6,003

Үйлдвэрийн хүчин чадал					
Цагийн хүчин чадал /Ad/	Т/цаг	1,661	1,661	1,661	5,000
Цагийн хүчин чадал /Ar/	Т/цаг	1,794	1,800	1,800	5,400
Хоногийн хүчин чадал	Т/хоног	38,753	38,877	38,877	116,631
Жилийн хүчин чадал	Т/жил	5,000,000	10,000,000	10,000,000	30,000,000

2.2 Төслийн ерөнхий төлөвлөлт

Тус үйлдвэрийг хоёр үе шаттай барьж байгуулахаар төлөвлөсөн бөгөөд нэгдүгээр үе шатанд 10 сая тн хүчин чадалтай эхний үйлдвэр, хоёрдугаар шатанд 20 сая тн хүчин чадалтай үлдсэн 2 үйлдвэрүүдийг ашиглалтад оруулах ба тус бүр нь 10 сая тн нүүрс боловсруулах хүчин чадал бүхий 3 үйлдвэрийг байгуулна. Нүүрс баяжуулах үйлдвэр нь 2323173, 2323174 нэгж талбарын дугаартай газарт нийтдээ 129,37 га талбайг хамарна. Нүүрс баяжуулах үйлдвэр нь дараах байгууламжуудаас бүрдэнэ. Үүнд:

- Түүхий нүүрс хадгалах байгууламж:
- Бүтээгдэхүүн хадгалах байгууламж:
- Нүүрс бутлах, шигшиж ангилах байгууламж:
- Нүүрс угаах байгууламж:
- Бүтээгдэхүүн, хаягдал усгуйжүүлэх байгууламж:
- Бүтээгдэхүүний хаягдал хадгалах байгууламж:
- Эргэлтийн усан сан:
- Цэвэр усан сан:
- Хаягдлын овоолгын талбай:
- Технологийн зам талбай:
- Авто машинд нүүрс ачих байгууламж:
- Вагонд нүүрс ачих байгууламж:
- Уурын зуух:
- Автожингийн байр:
- Бохир хуримтлуулах байр:
- Хог хаягдлын цэг:
- Туслан гүйцэтгэгч компаниудын барилга, байгууламж:
- Химийн бодис, шатах туслах материалын цэг:
- Аж ахуйн хэсгээс бүрдэнэ.



Зураг № 1. “Нүүрс баяжуулах үйлдвэр” төслийн ерөнхий төлөвлөлт

2.3 Ерөнхий гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгч байгууллагуудын мэдээлэл

Хүснэгт № 2. Туслан гүйцэтгэгч компаниудын мэдээлэл

Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байгууллагын хаяг
“Норинко Интернэйшнл Кооперэйшн” ХХК	Үндсэн гүйцэтгэгч	Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 15-р хороо, Хаан тауэр 23 давхар 2303 тоот
“Баяас Прайм Инженеринг” ХХК	Туслан гүйцэтгэгч - барилга	УБ, ХУД 18-р хороо, Академи сентер, 3 давхар
“Билгүүн Монгол Констракшн” ХХК	Туслан гүйцэтгэгч - барилга	Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 23-р хороо, 876 тоот
“Дулаан Баян Говь” ХХК	Бетон зуурмагийн үйлдвэр	Өмнөговь аймаг, Даланзадгад, 3-р баг Далан, Говь Сэндс төв 306 тоот

3. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

3.1 Уур амьсгал

Цогтцэций сумын уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Өөрөөр хэлбэл сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс эх газарлаг шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай, өвөл нь хүйтэн, үнэмлэхүй бага температур нь -14.8°C хүрдэг, үнэмлэхүй их температур нь 41.3°C хүрдэг байна. Хөрсний гадаргын дундаж температур нь ойролцоогоор 8.0°C .

Жилийн дундаж агаарын температур нь 0.9°C , хамгийн хүйтэн I сарын дундаж температур -14.6°C бол хамгийн дулаан сар болох VII сарын дундаж температур 23.1°C байдаг байна.

Цогтцэций суманд жилд дунджаар 76.7 мм хур тунадас ордог. Хур тунадасны жилийн явцыг авч үзэхэд зуны улиралд 52.7 мм буюу жилийн нийлбэр хур тунадасны 68 орчим хувь нь унадаг бол үлдсэн хувь нь зунаас бусад улирлуудад унадаг байна.

Салхины зонхлох чиглэлийн хувьд манай ерөнхий зонхилох чиглэл илэрдэг бөгөөд баруун хойноос нийт салхины чиглэлийн 38.8%, баруунаас 20.7%, баруунаас 9.4% давтагдалтай байдаг.

Салхины хурдны олон жилийн дундаж нь ойролцоогоор 5.1 м/с байдаг. Салхины хурдны жилийн явцаас авч үзвэл 4, 5 дугаар сард хамгийн их, харин хүйтний улиралд манай улсын нутагт төвтэй эсрэг циклон оршдог тул салхины хурд багасдаг боловч зарим жил 34 м/с хүрч шороон болон цасан шуурга шуурч байсан тохиолдол цөөнгүй.

3.2 Геоморфологи

Гадаргуугийн хувьд ерөнхийдөө нам уулс, жижиг толгод, талархаг гадаргуу зонхилох ба далайн түвшнээс дээш 1490-1590 м өргөгдсөн. Хамгийн өндөрлөг цэгүүд нь Таван толгойн талбайгаас баруун урагш орших Бага уул /1731.1 м/, зүүн хойно байх Майга улаан уул /1587.5 м/, чанх урагш орших Нэргүй өндөрлөг /1652.2 м/, зүүн урагш байх Таван толгой уул /1570 м/ зэрэг болно. Хамгийн нам цэгүүдэд Улаан нуур болон бусад нуур тойрмуудын хөндий орно. Голын хөндийнүүд нь ерөнхийдөө өргөргийн чиглэлтэй ба элсэрхэг, шаварлаг хурдсаар дүүргэгдсэн байдаг. Физик газар зүйн мужлалаар цөлийн ландшафттай говийн мужид хамаарах бөгөөд газар зүйн хэлбэр, гадаргуугийн хэв шинжээр цав толгод, ухаа гүвээт талын хэв шинжид багтана.

Гадаргуу нь гарал үүслийн шинж чанараа денудацийн буюу зөөгдлийн, структур-денудацийн, эрози-денудацийн буюу элэгдэл-зөөгдлийн, денудаци-хуримтлалын бүрдэлд хуваагддаг.

3.3 Хөрс

Хөрс газарзүйн мужлалтаар хөрс био-уур амьсгалын өргөргийн бүсчлэл бүхий Говийн мужийн Говийн цайвар бор, Цөлийн бор саарал хөрс бүхий 12-р тойрогт (Манлайн хөрсний тойрогт) багтана. Говийн цайвар бор зонхилон тархах бөгөөд урд хэсгээр Цөлийн бор саарал хөрстэй. Ерөнхий хөрсөн бүрхэвч нь доворхог хад чулуурхаг газрын гадаргын байдлаас шалтгаалж алаг цоог, хоршил зонхилно. Өндөрлөгдүү газраар нимгэн чулуурхаг, хотгордуу газраар ердийн Говийн цайвар бор хөрстэй. Лицензийн талбайн хойд хэсгээр нимгэн чулуурхаг хөрстэй байхад, урд хэсгийн хотгордуу газраар элсэрхэг дов ихтэй элэгдэл эвдрэлд амархан өртөмтгий сийрэг элсэн хөрс нилээд их талбай эзэлж байна. Хотгордуу газраар мараалаг хужирлаг шинжийн давсархаг хөрс хам бүрдэл үүсгэж бага зэрэг талбай эзэлнэ.

3.4 Ургамлан бүрхэвч

“Нүүрс баяжуулах үйлдвэр” төсөл нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт, ландшафт-экологийн мужлалаар Дундад говийн муж, Даланзадгадын районд гүвээ толгод бүхий уудам хөндий, хужир марцтай хотгор, цөлөрхөг хээрийн ургамал зонхилсон газар юм. Ургамал бүрхэвч нь газрын гадаргын байдал, хөрсний бүтэц, усан хангамжаас шалтгаалан таана-баглуурт, таана-хялгана, бор бударгана, улаан бударгана зэрэг эвшил бүлгэмдэлээс бүрдэх бөгөөд алтан харгана, дэрс, загсгал, догар, хотир зэрэг сөөг олон наст болон нэг наст өвслөг ургамлууд оролцдог байна. Нийтдээ 13 овгийн 51 төрлийн 75 зүйлийн бүрдэлтэй байна.

3.5 Нийгэм, эдийн засаг

Өмнөговь аймаг нь 2019 оны байдлаар нийт 113,349 хүн бүртгэгдсэнээс Цогтцэций суманд 8119 хүн бүртгэгдсэн байна. Уурхайн талбайтай хамгийн ойр орших суурин газар нь Цогтцэций сум юм. Тус сум нь Монгол улсын өмнөд хилээс 240 км, аймгийн төвөөс 100 км, нийслэл Улаанбаатар хотоос 540 км-т алслагдсан бөгөөд өмнө талаараа Баян-Овоо, баруун талаараа Ханхонгор, хойд талаараа Цогт-Овоо, Дундговь аймгийн Өлзийт сумтай, зүүн талаараа Манлай сумтай тус хил залгана.

Хүснэгт № 3. 2023 оны хүн амын тоо

Үзүүлэлт	Өмнөговь аймаг	Цогтцэций сум
Хүн амын тоо	76,153	10,194
Эрэгтэй	38,903	5,290
Эмэгтэй	37,250	4,904
Өрхийн тоо	25,336	3,225

Өмнөговь аймаг нь 2023 оны байдлаар 2042 мян тоо толгой мал тоологдсоноос Цогтцэций суманд 135.28 мян толгой мал тоологдсон байна.

Хүснэгт № 4. 2023 оны мал тоо


Аймаг, сум	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Өмнөговь	2,042	92.75	27.57	157.18	547.3	1,217.21
Цогтцэций	135.28	9.9	2.12	4.06	51.2	68

Цогтцэций сум нь Өмнөговь аймгийн 15 сум дотроо хамгийн бага буюу 700 гаруй га газар нутагтай. Түүний 16% нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй. Үүнээс төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК, “Энержи Ресурс” ХК нь Тавантолгойн бүлэг ордод идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр төсөл жилдээ 20 сая тн нүүрс олборлон экспортлож байна. Мөн хөрс хуулалт, тээврийн үйл ажиллагаанд 20-30 туслан гүйцэтгэгч гэрээт компаниуд оролцон үйл ажиллагааны эрчимд нөлөөлж байдаг.

Мөн 2019 оноос Улаанбаатар хотыг утаагүй болгох ажлын хүрээнд 100 орчим хүнд даацын машинууд нүүрс тээвэрлэж, зам дагуу нутагладаг малчдын бэлчээрийг талхалж, тоосжилт үүсгэн, өдөр шөнөгүй тээвэр хийж байна. Мөн замын дагуух худаг усыг бохирдуулах, хог хаягдал үүсгэх, зогссон газраа засвар үйлчилгээ хийж тос тосолгооны материалын асгаралтыг үүсгэж нь байгаль орчинд маш их нөлөө үзүүлж байна. Тус сумаас хот хоорондын төв зам хүртэл 59.6 км шороон зам байдаг нь үүнд нөлөөлж байна.

3.6 Төслийн талбайн байршил

Төслийн талбай нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Сийрст буюу 1-р багийн нутаг дэвсгэрт Улаанбаатар хотоос 540 км, аймгийн төв Даланзадгад хотоос зүүн зүгт 90 км, Цогтцэций сумын төвөөс зүүн өмнө зүгт 7 км зайд байрлана.



Зураг № 2. "Нүүрс баяжуулах үйлдвэр" төслийн байршилын зураг

Хүснэгт № 5. "Нүүрс баяжуулах үйлдвэр" төслийн талбайн хэмжээ

№	Аймаг, сум	Нутаг дэвсгэрийн хэмжээ, га
1	Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Сийрст баг	129,37

4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Энэ бүлгийн зорилго нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн захиалгаар ерөнхий гүйцэтгэгч “Норинко Интернэйшнл Кооперэйшн” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Нүүрс Баяжуулах Үйлдвэр” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин болон нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг үнэлж, дүн шинжилгээ хийж, тодорхойлон тооцоход оршино. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн захиалгаар “Хатандалай” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн “Тавантолгойн Ордыг Түшиглэн Байгуулагдах “Үйлдвэр Технологийн Парк” -ийн Хүрээнд Хэрэгжих “Нүүрс Баяжуулах Үйлдвэр” -ийн Байгаль Орчны Нөлөөллийн Нарийвчилсан Үнэлгээний Тайлан (цаашид БОННУ гэх) -д тусгасан төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг баримталлаа. БОННУ-д төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг их нөлөөлөл 11.6%, дунд зэргийн

нөлөөлөл 23.5%, бага нөлөөлөл 31.5%, нөлөөлөлгүй 33.4% гэж үнэлсэн ба дунджаар орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд дунд зэргийн нөлөөлөл үзүүлнэ гэж дүгнэжээ. Хамгийн их сөрөг нөлөөлөлд өртөх бүрэлдэхүүн хэсэг нь агаар болон хөрсөн бүрхэвч юм.

4.1 Эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн матриц

ISO 14001:2016 стандартын дагуу байгаль орчны гүйцэтгэлийн ач холбогдлын дарааллыг тодорхой болгох зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийсэн. Байгаль орчны асуудлыг тодорхойлж эдгээртэй холбоотой байгаль орчны нөлөөллийг тодорхойлсон. Нөлөөлөл тус бүрийн эрсдэлийн зэргийг тодорхойлсон

Хүснэгт № 6. Эрсдэлийн үнэлгээний матриц

Магадлал	Үр дагавар				
	Ялимгүй	Бага	Дунд	Их	Гамшиг
I бараг болохгүй	L	L	M	H	H
II магад болохгүй	L	L	M	H	E
III болзошгүй	L	M	H	E	E
IV магад болох	M	H	H	E	E
V лавтай болох	H	H	E	E	E

Хүснэгт № 7. Магадлалын үнэлгээний шалгуур

Түвшин	Зэрэг	Тайлбар
I	Бараг болохгүй	Онцгой нөхцөлд эрсдэлтэй байж магадгүй (<5%)
II	Болохгүй байж магад	Заримдаа эрсдэлтэй байж магадгүй (5-20%)
III	Болзошгүй	Заримдаа эрсдэл үүснэ (20-50%)
IV	Магад болох	Бараг бүх нөхцөл эрсдэл үүсгэж болзошгүй (50-70%)
V	Лавтай болох	Бараг бүх нөхцөл эрсдэлтэй (70-100%)

Хүснэгт № 8. Үр дагаварын үнэлгээний шалгуур

Зэрэглэл	Уршиг	Эрсдэлд өртөгч ба эрсдэлийн тодорхойлолт		Уршигийг бууруулах арилгах шийдэл
		Хүн ам	Эд хөрөнгө	
I	Ялимгүй	Техноген нөлөө арилахад хор уршиг арилна	Хохирол үгүй	Тусгай шийдэл шаардлагагүй
II	Бага	Бүс нутагт хуримтлагдах нөлөөлөл бий болгож био орчинд стресс учруулна	Багавтар хохирол	Уламжлалт арга хэмжээ, одоогийн горимыг мөрдөх
III	Дунд	Урт хугацаанд дэлхийн дулааралд хувь нэмэр оруулна	Дунд зэрэг хохирол	Уламжлалт арга хэмжээ, одоогийн чанд горимыг мөрдөх, зохион байгуулалтын өндөр түвшинд ажиллах
IV	Их	Хуримтлагдах сөрөг нөлөө үүсгэж урт хугацаанд экологийн тэнцвэр алдагдана	Их хохирол	Орчин үеийн технологи, өндөр сонор сэрэмж, зохион байгуулалтын хоршил, Тодорхой хэмжээний хөрөнгө зардал шаардана
V	Гамшиг	Байгаль орчинд эргэж буцахааргүй уршиг учруулж экологийн тэнцвэрт байдал алдагдахад хүрнэ	Маш их хохирол	Орчин үеийн технологи, өндөр сонор сэрэмж, зохион байгуулалтын хоршил. Их хэмжээний хөрөнгө оруулалт шаардана

Хүснэгт № 9. Байгаль орчны асуудал, нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээний хүснэгт

Үйл ажиллагаа	Асуудал	Нөлөөлөл	Магадлал	Үр дагавар	Эрсдэлийн зэрэглэл	Хариу арга хэмжээ	Бүлгийн дугаар
1	2	3	4	5	6	7	8
	Дулаан түгээх		4	1	II	Мод тарих	

Ажилчдын хотхон		Хүлэмжийн хий үүснэ	4	1	II	Түлш зарцуулалтын хяналт	
	Их хэмжээний хог хаягдал	Лэндфилийн талбай нэмэгдэнэ	5	4	IV	Хог хаягдлын ангилан ялгалт	
			5	4	IV	Хог хаягдлын гарцыг хянах	
Барилга шинээр байгуулах	Газар шорооны ажил	Тоосжилт	4	3	III	Тоос бууруулах арга хэмжээ	
		Хөрсний эвдрэл	4	3	III	Хөрсний өөрчлөлтийн хяналт	
			4	3	III	Хөдөлгөөний хязгаарлалт	
Засвар, угсралт эрхлэх	Ашигласан сэлбэг, хэрэгсэл хаягдана	Хөрсний бохирдол	4	4	IV	Хог хаягдлын ангилан ялгалт, дахин боловсруулалт	
			4	4	IV	Хог хаягдлын гарцыг хянах	
			4	4	IV	Ажлын байрны тогтмол үзлэг	
	Бохирлогдсон материал хаягдах		4	3	III	Аюултай бодисын удирдлага	
			4	3	III	Хөрсний бохирдлын хяналт	
	Тос, шинэгн материал хаягдана		4	4	IV	Асгаралтаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө	
			4	4	IV	Хөрсний бохирдлын хяналт	
	Химийн бодисийн алдагдал		4	4	IV	Асгаралтаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө	
			4	4	IV	Аюултай бодисын хяналт, бүртгэл	
			4	4	IV	Ажлын байрны эмх цэгц	

4.2 Газрын гадарга, хэвлий

Төслийн барилгын ажлын үед шатах тослох материал алдагдах, хог хаягдлын менежментийг хангалтгүй хийснээс хог хаягдлаар бохирдох, газрын гадарга эвдрэлд орох зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй. Тус талбай нь хойноосоо урагш уртрагийн дагуу сунаж тогтсон учир хотгор гүдгэрийн хувьд дундаж өндөр, нам уулс, цав толгод, хөндий хотгор хосолсон бөгөөд ерөнхийдөө долгиорхог тэгш гадаргатай.

4.3 Агаарын чанар

Төсөлд ашиглах тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр түр зам, талбайгаас тоосжилт үүсэж агаарын чанарт нөлөөлж болзошгүй. Мөн төсөлд ашиглах техник хэрэгслүүдээс нүүрсхүчлийн хий, хүхэрлэг хий, азотын исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл ялгарч, агаарын чанарын найрлагад түр хугацаанд бага хэмжээгээр нөлөөлнө.

4.4 Уур амьсгал

Төслийн талбайд ашиглах техник хэрэгслүүдээс хүлэмжийн хийн гол бүрэлдэхүүн болох нүүрсхүчлийн хий ялгарч агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг бага хэмжээгээр нэмэгдүүлнэ.

4.5 Гадаргын болон газрын доорх ус

Төслийн талбайд ажиллах тээврийн хэрэгслүүдэд эвдрэл, гэмтэл гарсан үед болон ажилчдын санамсар болгоомжгүй байдал, байгалийн давагдашгүй хүчин зүйлээс гэнэтийн осол гарч шатах тослох материал асгарсан тохиолдолд хөрс бохирдож, улмаар хур тунадас орсон үед үерийн усаар дамжин гадаргын түр урсац болон газрын доорх усыг бохирдуулж болзошгүй.

4.6 Ургамлан нөмрөг

Төсөл хэрэгжүүлэх талбай, барилгын ажилд ашиглагдах түр зам, кемп байгуулах газрууд бүтээн байгуулалтын үед нөлөөлөлд өртөнө. Бүтээн байгуулалтын дараа “Нөхөн сэргээлт, орчны тохижуулалтын төлөвлөгөө”-ний дагуу нөлөөлөлд өртсөн талбай, газруудыг холбогдох стандартын дагуу нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.7 Амьтны аймаг

Төслийн үйл ажиллагааны улмаас амьтны аймагт дараах нөлөөлөл, үр дагаврууд бий болж болзошгүй. Төслийн үндсэн үйл ажиллагаа хөрс шүтэн амьдрагч мэрэгч амьтад, мөлхөгчид болон шавжийн зүйлийн бүрдэл, тоо толгойг бууруулах, амьдрах орчныг алдагдуулах сөрөг нөлөө үүсэх магадлалтай. Хөрсний эвдрэл, доройтол, орчны тоосжилтын улмаас ургамал идэшт амьтдын тоо толгой буурах нөлөөлөл гарч болзошгүй. Төслийг хэрэгжүүлэх явцад амьтдын амьдрах орчин өөрчлөгдөж, шинээр бий болсон орчинд тухайн нутагт өмнө нь тохиолдож байгаагүй, эсвэл тоо толгой нь цөөн байсан амьтад олноор шилжин суурьшиж болзошгүй тул амьтдын унаган амьдрах орчныг бүрдүүлэх, амьтны төрөл зүйлийг сэргээхэд анхаарах шаардлагатай.

4.8 Тусгай хамгаалалттай газар нутаг

Төслийн талбай нь дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, байгалийн дурсгалт газарт хамаарахгүй тул тэдгээр газруудад шууд нөлөөлөх сөрөг нөлөөлөл байхгүй байна.

4.9 Дуу шуугиан

Төслийн бүтээн байгуулалтын үед төслийн талбайд ажиллах тээврийн хэрэгслээс үүдэлтэй дуу шуугиан үүсч болзошгүй. Төсөл хэрэгжих талбайд дуу шуугианы хэмжилтийн хамгийн их утга нь 77.5 дба, дундаж нь 53 дба, хамгийн бага утга нь 39.2 дба байна.

4.10 Нийгэм, эдийн засаг

Үйлдвэрийн бүс, овоолгын үйл ажиллагаанаа үүсэх тоосжилт төслийн талбайн ойролцоох нөлөөллийн бүсэд хамрагдах малчин өрх, байгаль орчинд нөлөөлөх магадлалтай. БОННУ-нд төслийн талбайгаас 3 км радиус дотор байгаа айлыг нөлөөллийн бүс гэж үзнэ гэж тусгасан.

4.11 Түүх, соёлын дурсгалт зүйлс

Төслийн талбай болон түүний ойр орчимд түүх, соёлын дурсгалт зүйлс өнөөгийн байдлаар тодорхойлогдоогүй байна. Энэхүү төсөл хэрэгжүүлэх явцад мэдэгдээгүй түүх дурсгалын зүйлс, булш, бунхан хиргисүүр, археологи, палеонтологийн зүйлс илрэх тохиолдолд түүх соёлын үнэт өвийг хамгаалах үүднээс үйл ажиллагаагаа зогсоож хамгаалалт гарган зохих хууль ёсны дагуу мэргэжлийн байгууллагад мэдэгдэх, улмаар тухайн газар нутгийг бүрэн хамгаалалтанд авах зэрэг арга хэмжээг авах шаардлагатай.

4.12 Хог хаягдлын менежмент

Түр кемп, төслийн талбайд ажиллаж буй ерөнхий болон туслан гүйцэтгэгч нарын үйл ажиллагаанаас аюултай болон ахуйн хог хаягдлууд үүсч санамсар болгоомжгүй байдлаас үүдэн хаягдал асгарч алдагдсанаас болж хүрээлэн буй орчныг бохирдуулж болзошгүй. Төслийн барилга, байгууламжуудын барилга угсралтын үйл ажиллагааны үед бий болох хаягдал, тэдгээрийн устгал, зайлуулалтын улмаас байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллүүдийг хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх замаар үр ашигтай зохион байгуулж, бууруулж болно. Энэ нь төслийн байгаль орчны менежментийн чухал хэсэг болно.

5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

“Нүүрс Баяжуулах Үйлдвэр” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд тухайн төслийн хэрэгжилтийн явцад буюу 2022-2026 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав. Мөн “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолоор баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам” болон уг төслийн БОННУ-г үндэс болгов.

Энэхүү төлөвлөгөөний зорилго нь тухайн төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, бохирдлоос сэргийлэх, ерөнхий үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийг төлөвлөх, хэрэгжилтийн үр дүнг тогтооход оршино. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдсэн.

Төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг бэлтгэл, барьж байгуулах болон ашиглалтын үе шатны батлагдсан төлөвлөгөөтэй уялдуулан жил бүрийн эхний улиралд багтаан боловсруулж батлуулна (А/618-журмын 2.15 дахь заалт).

6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

6.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
6.1.1	Барилгын ажлын үед үүсэх тоосжилтыг дарахын тулд зам, талбайг услах	Төслийн хугацаанд	Барилга угсралт болон түр замын ажлын үед үүсэх тоосжилт дарах усалгаанд 14490 м ³ усыг ашигласан.	100%
6.1.2	Цэвэрлэх байгууламжтай ААН-д гэрээгээрээ шингэн хаягдлаа нийлүүлэх	Сар бүр	Төслийн хэмжээнд 3 бохирын цэгтэй ба тус цэгүүд септик танк болон кольцоогоор хийгдсэн. Хэрэглээнээс гарсан 504 м ³ саарал усыг “Арцат шанх” ХХК-тай гэрээ байгуулж цэвэрлэх байгууламжид нийлүүлж 21.560 сая төгрөгийг төлсөн байна.	100%
6.1.3	Хаягдлын овоолгын усалгаа хийж дагтаршуулах	1 ш	Баяжуулах үйл ажиллагаа эхлээгүй байгаа тул одоогоор хаягдал гараагүй байна.	100%

6.1.1 Барилгын ажлын үед үүсэх тоосжилтыг дарахын тулд зам, талбайг услах

Барилгын ажлын үед үүсэх тоосжилтыг дарах зорилгоор 14490 м³ усыг түр замын усалгаанд ашигласан. Усалгаанд “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн худгаас ус авч ашигласан.



Зураг № 3. Түр замын тоосжилт дарах усалгаа хийж буй байдал

6.1.2 Цэвэрлэх байгууламжтай ААН-д гэрээгээрээ шингэн хаягдлаа нийлүүлэх

Төслийн хэмжээнд 3 бохирын цэгтэй ба тус цэгүүд септик танк болон кольцогоор хийгдсэн тул хөрсөнд бохирдол үүсгэхгүй. Хэрэглээнээс гарсан 504 м³ саарал усыг “Арцат шанх” ХХК-тай гэрээ байгуулж цэвэрлэх байгууламжинд нийлүүлж 21.560 сая төгрөгийг төлсөн.



Зураг № 4. Гэрээт байгуулагаар бохир ус тээвэрлүүлж буй байдал

6.1.3 Хаягдлын овоолгын усалгаа хийж дагтаршуулах

Нүүрс баяжуулах үйлдвэр бүрэн ашиглалтанд ороогүй байгаа учраас одоогоор нүүрс баяжуулах үйл ажиллагаа эхлээгүй байна. Зөвхөн туршилт охируулгын ажил хийгдэж байна.

Туршилт тохируулгын ажлын хүрээнд бага хэмжээний нүүрсийг угааж байгаа тул хаягдлын даланд хаягдал хуримтлагдаагүй байна.

Хаягдлын далангийн газар эзэмших, ашиглах эрхийг Цогтцэций сумын 2024 оны Иргэдийн төлөөлөгчдийн хуралд оруулж дэмжүүлсэн боловч Засгийн газраас татгалзсан байсныг албан бичгээр хүсэлт илгээж 2024 оны 10-р сарын 15-ны өдөр баталгаажсан. Одоогоор хаягдлын далан байрших талбайн төлөвлөгөөний ажил хийгдэж байна.

6.2 Газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
6.2.1	Өнгөн хөрсний овоолгыг 2 жил ашиглахгүй бол стандартын дагуу хадгалах	5000 м ³	MNS5916:2008 “Газар шорооны ажлын үед шимт хөрс, хуулалт хадгалалт” стандарт, NOR-HSE-ENV-PRC-003-0 Өнгөн хөрстэй ажиллах журмын дагуу 1 м өндөртэй овоолго үүсгэж, хэлбэржүүлэлт хийж, хадгалсан.	100%
6.2.2	Тусгай зөвшөөрөл бүхий ААНБ-аас ТТАМ-ийг ашиглах, гэрээ, бичиг баримтын бүрдлийг хангах	-	Бетон зуурмагийн үйлдвэрт тусгай зөвшөөрөл бүхий “Өгөөмөр гавилууд” ХХК, “Өсөх говь” ХХК-аас тус тус 21,406.2 м ³ хайрга, дайрга, “Сауд гоби капитал” ХХК-аас 16,950 м ³ элс татан авсан.	100%
6.2.3	Замын маршрутын батлуулж зөвхөн батлагдсан маршрутаар зорчих	-	Цогтцэций сумын Засаг даргын 2023 оны А/140 дүгээр захирамжаар Цогтцэций сум – НБҮ төслийн талбай хүртэлх замын маршрут, 2023 оны А/311 дүгээр захирамжаар ТТГС хатуу хучилттай автозамын 4 дэх км-ээс НБҮ төслийн талбай хүртэлх замын маршрутыг тус тус батлуулж, тээврийн хэрэгслүүд зорчиж байна.	100%
6.2.4	Эвдрэлд өртсөн газрыг байгалийн унаган төрхөнд нь дөхүүлэн хэлбэршүүлэх	-	Үйлдвэрийн барилга байгууламж, шугам хоолой газар шорооны үед өртсөн газруудыг байгалийн унаган төрхөнд нь дөхүүлэн хэлбэршүүлсэн.	100%

6.2.1 Өнгөн хөрсний овоолгыг 2 жил ашиглахгүй бол стандартын дагуу хадгалах

MNS5916:2008 “Газар шорооны ажлын үед шимт хөрс, хуулалт хадгалалт” стандарт, NOR-HSE-ENV-PRC-003-0 Өнгөн хөрстэй ажиллах журмын дагуу 1 м өндөртэй овоолго үүсгэж, хэлбэржүүлэлт хийж, хадгалсан.



Зураг № 5. Өнгөн хөрсний хэлбэржүүлэлт хийж буй байдал

6.2.2 Тусгай зөвшөөрөл бүхий ААНБ-аас ТТАМ-ийг ашиглах, гэрээ, бичиг баримтын бүрдлийг хангах

Бетон зуурмагийн үйлдвэрт тусгай зөвшөөрөл бүхий “Өгөөмөр гавилууд” ХХК, “Өсөх говь” ХХК-аас тус тус 21,406.2 м³ хайрга, дайрга, “Сауд гоби капитал” ХХК-аас 16,950 м³ элс татан авсан.

Хүснэгт № 10. Гэрээгээр худалдан авсан хайрга, дайрганы хэмжээ

№	Компани	“Өгөөмөр гавилууд” ХХК	“Өсөх говь” ХХК	Нийт
1	Дулаан баян говь ХХК	2525	5400	7,925
2	Болор оргил юниан ХХК	2323.9	11,157.3	13,481.2
Нийт		4848.9	16,557.3	21,406.2

Хүснэгт № 11. Татан авсан элсний хэмжээ

№	Компани	“Сауд гоби капитал” ХХК
1	Дулаан баян говь ХХК	3000
2	Болор оргил юниан ХХК	13,950
Нийт		16,950

6.2.3 Замын маршрутын батлуулж зөвхөн батлагдсан маршрутаар зорчих

Цогтцэций сумын Засаг даргын 2023 оны А/140 дүгээр захирамжаар Цогтцэций сум – НБҮ төслийн талбай хүртэлх замын маршрут, 2023 оны А/311 дүгээр захирамжаар ТТГС хатуу хучилттай автозамын 4 дэх км-ээс НБҮ төслийн талбай хүртэлх замын маршрутыг тус батлуулж, тээврийн хэрэгслүүд зорчиж байна.



Зураг № 6. Замын маршрутын зураг


北方国际 NORINCO International “Норинко Интeргaйшлa Кooпepaцнa Лтд- Кoaл Хaндлнг Тaлaвнaй Гaзaр” Norinco International Cooperation Ltd.- Coal Handling PE

ЗАМЫН МАРШРУТ ТАНИЛЦУУЛСАН БҮРТГЭЛ
Баримт бичгийн дугаар / Reference No:

ОГНОО, ЦАГ / DATE AND TIME: 2024.04.06

Цогцидий сум – НБҮ төсөл
ТТТС автозамын 4хх км – НБҮ

МАРШРУТ / ROAD:



№	Харьяалагдах компани	Албан тушаал / Position	Овог, Нэр / Surname, Name	Гарын үсэг / Signature
1	Norinco	Монитор	Н.Балжинням	Балжинням
2	Norinco	Харьяалагч	А.Түвшин	Түвшин
3	Norinco	Манагер	М.Орлов	Орлов
4	Norinco	Коммерциал Оффис	З.Анхбаяр	Анхбаяр
5	Norinco	Зам	Э.Сэлэнгэ	Сэлэнгэ
6	Norinco	Малгоос	Х.Одгояр	Одгояр
7	Norinco	Эксп/инженер	Б.Сүхбаатар	Сүхбаатар
8	“ОАТ” ХХЕ	ХАБЭАИ харьяалагч	Г.Морин	Морин
9	Norinco	Эрүү ажил	Б.Балжинням	Балжинням
10	Norinco	ОАБС	М.Бат-Зориг	Бат-Зориг
11	Norinco	ХАБ ТИОАБС	В.Анхбаяр	Анхбаяр
12	Norinco	Оффис	О.Молдогов	Молдогов
13	Norinco	БИ	Ц.Мөнхсайхан	Мөнхсайхан
14	NORINCO	ITL OFFICER	А.Доржиев	Доржиев
15	NORINCO	Ажиг шалтгар	М.Бадар	Бадар

Зураг № 7. Замын маршрутын ажилтнуудад танилцуулсан бүртгэл

6.2.4 Эвдрэлд өртсөн газрыг байгалийн унаган төрхөнд нь дөхүүлэн хэлбэршүүлэх

Үйлдвэрийн барилга байгууламж, шугам хоолой газар шорооны үед өртсөн газруудыг байгалийн унаган төрхөнд нь дөхүүлэн хэлбэршүүлсэн.



Зураг № 8. Эвдрэлд өртсөн газруудыг буцаан байгалийн унаган төрхөнд ойртуулан сэргээсэн байдал

6.3 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
6.3.1	Бохир ус цэвэрлэх байгууламж байгуулах	1 ш	Шинээр байгуулагдаж буй оффис ажилчдын хотхонд шинээр цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил хийгдсэн.	100%
6.3.2	Хог хаягдлын түр цэгт тогтмол хяналт тавьж ажиллах	-	Хог хаягдлын түр цэгийн хог хаягдлыг 7 хоногт 4 удаа тогтмол ачиж байна.	100%
6.3.3	Шимт хөрсний овоолгыг нимгэн материалаар хучиж хадгалах	5000 м3	Нүүрс баяжуулах үйлдвэрийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх ажлын төсвийн компанийн 2024 оны төсөвт суулган батлуулж уг төсвийн хүрээнд тендер шалгаруулалт зарлаж “Ийрт Плас” ХХК шалгарч ажил хийж байна. Уг гэрээний ажлын даалгаварт шимт хөрсний удаан хугацаагаар хадгалагдах 5000 м3 овоолгыг агаар нэвтрүүлдэг нимгэн материалаар хучиж цаг агаарын эрсдэлээс сэргийлэх ажлыг тусгасан.	100%
6.3.4	Химийн бодисын сав баглаа боодлын хаягдлын талбай байгуулах	1 ш	Хог хаягдлын тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу Аюултай хог хаягдлын цэгийг байгуулсан.	100%

6.3.1 Бохир ус цэвэрлэх байгууламж байгуулах

Иргэний барилгын бохир ус цэвэрлэх байгууламжийг “Алтайн эколог” ХХК-аар 1 хоногт 112 м3 буюу 9 ш “Топол эко” төхөөрөмж суурилуулж гүйцэтгүүлсэн.



Зураг № 9. Цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын үеийн зураг

6.3.2 Хог хаягдлын түр цэгт тогтмол хяналт тавьж ажиллах

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг даргаар 2023.10.16-ны өдөр А/370 дугаартай, 2024.03.25-ны өдөр А/85 дугаартай “Хог хаягдлын цэг тогтоох тухай” захирамжийг тус гаргуулсан бөгөөд хог хаягдлын түр цэгийн өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол хяналт шалгалт хийж ажилласан.

**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЦОГТЦЭЦИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

Хог хаягдал түр хадгалах цэг
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- Тус сумын Цагаан овоо багийн нутаг дэвсгэрт нүүрс олборлох үйл ажиллагаа явуулж байгаа “Ордэнэс Тавантолгой” ХК-ийн хог хаягдал түр хадгалах цэгийг тогтоосугай.
- Хог хаягдал түр хадгалах цэгийн солбицлыг хавсралтаар баталсугай.
- Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагаан овоо багийн Засаг дарга (Б.Энхбаатар), Байгаль орчны хяналтын улсын байцаагч (З.Наранмандах) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Г.БАЦМАА

ХОГ ХАЯГДАЛ ТҮР ХАДГАЛАХ
ЦЭГИЙН БАЙРШИЛ


№	Зориулалт	Солбицол	
		X	Y
1	Цахиу жолон	43°42'22.22"N	105°29'29.76"E
2	Нөхөн сэргэлтийн тунцгийн талбай	43°42'0.07"N	105°28'45.78"E
3	Засварил газрын аюултай хог хаягдлын талбай	43°38'49.63"N	105°29'4.34"E
4	Цахиуны баруун уурайн хог хаягдлын байгууламж “Тэдэсний оператор тунцалт”	43°38'7.75"N	105°29'10.41"E
5	Цахиуны баруун уурайн хог хаягдлын байгууламж “Хэй Эн Майнинг” ХХК	43°38'19.04"N	105°29'0.05"E
6	Зүүн цахиуны уурайн хог хаягдлын байгууламж “Ти Эн Тунцалт” ХХК	43°38'57.01"N	105°29'21.16"E
7	Тавантолгой нүүрс ашигт малтмалын төв	43°38'56.47"N	105°29'53.50"E
8	Нүүрс ашигтын талбай тээврийн хэрэгсэлийн зогсоол	43°39'20.32"N	105°28'46.65"E
9	Нүүрс тээврийн хэрэгсэлийн А талбайн зогсоол	43°39'15.47"N	105°30'30.37"E
10	Зэвсгийн усны гүний усны жолооны өрхөж хавсас станц	44°0'11.39"N	105°25'3.21"E

Зураг № 10. Хог хаягдлын түр цэг тогтоосон тухай Цогтцэций сумын Засаг даргын А/85 дугаартай захирамж

6.3.3 Шимт хөрсний овоолгыг нимгэн материалаар хучиж хадгалах

Нүүрс баяжуулах үйлдвэрийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд компанийн 2024 оны төсөвт шимт хөрсний овоолгыг салхинд хийсч, үржил шим нь алдагдахаас сэргийлж нимгэн материалаар хучих ажлыг тусгасан. Тендер шалгаруулалтаар байгаль орчны зөвлөх үйлчилгээний “Ийрт Плас” ХХК шалгарч БОМТ хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэсэн.

Нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын үйл ажиллагаанаас гарсан шимт хөрсийг удаан хугацаанд хадгалах, цаашид нөхөн сэргээлтэд ашиглах, үржил шимийн алдагдлаас сэргийлэх үүднээс 5000 м³ овоолгыг агаар нэвтрүүлдэг зориулалтын нимгэн материалаар хучих ажлыг хийж гүйцэтгэсэн.



Зураг № 11. Шимт хөрсний овоолгыг зориулалтын материалаар хучсан байдал

6.3.4 Химийн бодисын сав баглаа боодлын хаягдлын талбай байгуулах

Хог хаягдлын тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу Аюултай хог хаягдлын цэгийг байгуулсан. Үүнд:

- Үл нэвчих бетонон гадаргуутай, хальж урсахаас хамгаалсан хашилт, хөмсөгтэй
- Хур тунадас, нарны тусгалаас хамгаалсан дээвэртэй
- Хадгалж буй ААХ-тойгоо урвалд ордоггүй, бат бөх төмөр савтай
- Тэмдэг, тэмдэглэгээ, галын хортой




Зураг № 12. Аюултай хог хаягдал хадгалах цэг

6.4 Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
Тоосны агууламжийн хэмжилтийг олон улсад түгээмэл ашиглагддаг багаж төхөөрөмж ашиглан хэмжилтийг хийсэн. Хэмжилтийн үр дүнгээс харахад нарийн ширхэглэгт тоосонцор PM2.5 нь Монгол улсын Агаарын чанар. Техникийн шаардлага стандарт MNS 4585:2016-ын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 4,5,8-р саруудад 2-3 дахин өндөр, том ширхэглэгт тоосонцор PM10 нь стандартаас 4,5,8-р саруудад 2-3 дахин хэтэрсэн үзүүлэлтэй гарсан байна.

10.1.2 Хийн төлөвт агаар бохирдуулагчийн шинжилгээ

Өмнөговь аймгийн УЦУОШТ-ийн лабораториар гадаад орчны агаарын шинжилгээг 3 цэг /Иргэний барилга, Бетон зуурмагийн үйлдвэр, Үндсэн үйлдвэр/-т 2024 оны 5 сард гүйцэтгүүлсэн. Шинжилгээний дүнгээр MNS4585:2016 стандартаас хүхэрлэг хий (SO₂) азотын давхар исэл (NO₂) бага байна.

Хүснэгт № 18. Хийн төлөвт агаар бохирдуулагчийн шинжилгээний дүн мэдээ

№	Компани	Байршил	NO ₂	SO ₂	CO
			/мкг/м ³ /		
1	“Эрдэнэс Тавантолгой” ХК	Бетон зуурмагийн үйлдвэр	<19	<8.7	4608.7
2		Нүүрс баяжуулах үйлдвэр	<19	<8.7	57260
3		Кемпийн гадна орчин	<19	<8.7	34360
MNS4585:2016 /20 минутын дундаж/			85	450	60000



Зураг № 43. Гадаад орчны агаарын найрлага дахь SO₂, CO, NO₂ хийнүүдийг хэмжилт хийж буй байдал

10.1.3 Дуу чимээний хяналт

Үйл ажиллагаанаас шалтгаалан гарч буй дуу чимээний тархалтыг тодорхойлон дуу чимээг үндэсний стандартад нийцэж байгаа эсэхийг харицуулж дүн шинжилгээ хийн, дуу чимээний түвшин зөвшөөрөгдөх хэмжээнд байлгах зорилгоор хэмжилтийг хийж гүйцэтгэв.




Зураг № 44. Дуу шуугиан (гадаад орчны дуу шуугианы түвшин)-ны хэмжилт хийж буй байдал

Хүснэгт № 19. Дуу шуугианы хэмжилтийн дүн

Огноо	Цэг-1 Баруун урд Бетон зуурмагийн үйлдвэр			Цэг-2 Зүүн Үндсэн үйлдвэр			Цэг-3 Баруун Иргэний барилга			MNS4585:2016 ЗДХ, дба
	Min	Max	Average	Min	Max	Average	Min	Max	Average	
2024.04.09	46.6	60.6	53.6	54.3	66.6	60.45	51.1	64.6	57.8	85
2024.09.30	47.2	49.9	48.5	58.	61.9	59.9	47.3	61.5	54.4	85
MNS4585:2016 ЗДХ, дба	85	85	85	85	85	85	85	85	85	85

Дуу шуугианы хэмжилтийг PCE-EM882 Multi-Function environment meter, PCE-EM883 2ш багажаар хийж гүйцэтгэсэн. Мөн 1 цэг дээрх хэмжилтийн үргэлжлэх хугацаа 30 мин байх ба тухайн хэмжилтийн багаж нь өөр дээрээ бичилт хадгалдаггүй тул 3 минут тутам хэмжилтийн утгыг хавсралтанд заасан маягтанд гараар бичиж хөтлөв.



Диаграмм № 4. Дуу шуугианы хэмжилтийн үр дүнг зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй харьцуулсан диаграмм

10.2 Хөрсөн бүрхэвчийн хяналт, шинжилгээ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
10.2.1	Хөрсөн дэх хүнд металлын агууламж	3 цэгт хагас жил тутам	НБҮ төслийн Үндсэн үйлдвэр, Бетон зуурмагийн үйлдвэр, Засварын талбай гэсэн 3 цэгээс хөрсний дээж авч Хөрсний итгэмжлэгдсэн лабораторид хөрсний хүнд металлын үзүүлэлтүүдийг шинжлүүлсэн.	100%
10.2.2	Агрохими	3 цэгт хагас жил тутам	НБҮ төслийн Үндсэн үйлдвэр, Иргэний барилга, Бетон зуурмагийн үйлдвэр гэсэн 3 цэгээс хөрсний дээж авч Хөрсний итгэмжлэгдсэн лабораторид хөрсний химийн үндсэн үзүүлэлтүүд, механик бүрэлдэхүүнийг шинжлүүлсэн.	100%
10.2.3	Нянгийн бохирдол	3 цэгт хагас жил тутам	НБҮ төслийн оффис, кемп, түүхий нүүрсний агуулах гэсэн 3 цэгээс хөрсний дээж авч Хөрсний итгэмжлэгдсэн лабораторид хөрсний нянгийн бохирдлыг шинжлүүлсэн.	100%

10.2.1 Хөрсөн дэх хүнд металлын агууламж

Нүүрс баяжуулах үйлдвэрийн орчмоос хөрсний хүнд металлын шинжилгээг бетон зуурмагийн үйлдвэр, засварын төв, нүүрс баяжуулах үндсэн үйлдвэр орчмоос авсан бол хөрсний агрохимийн шинжилгээг иргэний барилга, нүүрс баяжуулах үндсэн үйлдвэр, бетон зуурмагийн үйлдвэр орчмоос, хөрсний нянгийн бохирдлын шинжилгээг гэр кемп, түр оффис, түүхий нүүрсний агуулах орчмоос авсан.



Зураг № 45. НБУ-ийн хөрсний дээж цуглуулалт

Хүснэгт № 20. Хөрсний хүнд металлын шинжилгээний дүнгийн хүснэгт

№	Дээжний нэр	Огноо	Хүнд металл мг/кг					
			Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/
1	NBU01	2024.03.20	29.3	ND	37.9	15.9	74.3	48.6
2	NBU02		33.8	ND	25.8	18.3	61.7	42.1
3	NBU03		37.2	ND	28.8	9.8	79.8	33
4	NBU01	2024.08.13	13.26		14.68	26.86	51.17	20.4
5	NBU02		11.95		6.44	16.87	6026	3.94
6	NBU03		9.41		0.59	6.76	46.7	

10.2.2 Агрохими

“Инженер геодези” ХХК-тай Хөрсний шинжилгээ хийлгэх ЭТТ-2023/178-01 дугаартай нэмэлт гэрээ байгуулан уурхайн ахилтын талбай, бохирдлын эрсдэлтэй цэг, хяналтын цэгүүдээс хөрсний дээж авч химийн задлан шинжилгээ, механик бүрэлдэхүүн, шим тэжээлийн бодис, хүнд металл зэргийг тодорхойлуулж ажилласан.

Хүснэгт № 21. Хөрсний химийн задлан шинжилгээний дүн

Date	Source	Ph	Давс, %	ЦДЧ, dsm	Ялзмаг, %	NO3 мг/100г	Нийт Азот, %	CaCO2, %	Ca	Mg	SO4	P	K	Fe
2024.08.13	NBU01	9.04	0.03	0.077	0.18	0.05		2.97	8.4	4.6		0.5	19	
	NBU02	9.11	0.06	0.124	0.45	0.19		0.99	4.2	3.6		1.3	31	
	NBU03	9.03	0.06	0.128	0.68	0.83		0.32	8.3	6.6		2.1	31	
2024.09.10	Үндсэн үйлдвэр	8.46			1.2	0.8	25.5				45.9	8.3		
	Иргэний барилга	8.22			0.91	1.8	30.2				4.3	8		
	Бетон зуурмагийн үйлдвэр	8.42			0.79	4.1	21.4				11.5	5.5		

Хүснэгт № 22. Хөрсний механик бүрэлдэхүүний задлан шинжилгээний дүн

№	Дээжний нэр	Огноо	1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
1	NBU01	2024.03.20	18.8	53.1	12.3	1.5	13.7	0.5	15.7
2	NBU02		25	60.9	1.5	2.4	3.4	6.9	12.7
3	NBU03		25.5	43.7	2.2	0.1	7.4	21.1	28.6
4	NBU01	2024.08.13	17	55.8	9	4.3	9.8	4	18.1
5	NBU02		25.1	53.7	5.8	2.4	8.6	4.4	15.4
6	NBU03		18.3	52	6.3	2.3	11.7	9.4	23.5

10.2.3 Нянгийн бохирдол

НБУ төслийн оффис, кемп, түүхий нүүрсний агуулах гэсэн 3 цэгээс хөрсний дээж авч Хөрсний итгэмжлэгдсэн лабораторид хөрсний нянгийн бохирдлыг шинжлүүлсэн.

Хүснэгт № 23. Хөрсний нянгийн шинжилгээний хариу

№	Дээжний нэр	Бактерийн ерөнхий тоо	Колиформгэдэсний бүлгийн нянгийн тарьц	Халуунд тэсвэртэй нян	Клостридиум перфрингенсийн тарьц	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян
2024.09.09	Гэр кемп	1*10 ⁴	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй
	Түр оффис	6.5*10 ⁴	Илрэв /0.0001/	Илрээгүй	Илрэв /0.1/	Илрээгүй
	Түүхий нүүрсний агуулах	1.5*10 ⁵	Илрэв /0.01/	Илрээгүй	Илрэв /0.01/	Илрээгүй
Зөвшөөрөгдөх дээж хэмжээ /MNS 3297:1991/		Илрэхгүй 1г-д	Илрэхгүй 1г-д	Илрэхгүй 1г-д	Илрэхгүй 1г-д	Илрэхгүй 25г-д

Шинжилгээний хариуг Монгол улсын стандарттай хариуцуулахад Колиформгэдэсний бүлгийн нянгийн тарьц, Клостридиум перфрингенсийн тарьцын нян илэрсэн байна.

10.3 Усан орчны хяналт шинжилгээ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
10.3.1	Усны хими, физикийн ерөнхий шинжилгээ	4 цэгт улирал тутам	Төслийн үйл ажиллагаанд ашигладаг 2 худгаас усны ерөнхий химийн шинжилгээнд дээж авч, Газарзүй-Геозкологийн хүрээлэнгийн Усны шинжилгээний лаборатори, “Ханлаб” итгэмжлэгдсэн лабораторид 5, 9, 10 саруудад шинжлүүлсэн. Малчны 1 худаг /Хадан усны худаг/-аас дээж авч 7, 9 саруудад шинжлүүлсэн.	100%
10.3.2	Худгуудын бактериологийн шинжилгээ усны	4 цэгт жилд 1 удаа	“Ийрт Плас” ХХК-тай байгуулсан ЭТТ-2024/1397 тоот гэрээний дагуу Төслийн үйл ажиллагаанд ашигладаг 2 худаг /НБҮ худаг, ТТЗ худаг/, малчны 1 худаг /Хадан усны худаг/-аас дээж авч шинжлүүлсэн мөн “Ханлаб” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.	100%
10.3.3	Микробиологи	4 цэгт жилд 1 удаа	Төслийн үйл ажиллагаанд ашигладаг 2 худаг /НБҮ худаг, ТТЗ худаг/, малчны 1 худаг /Хадан усны худаг/-аас дээж авч Өмнөговь аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн лабораторид шинжлүүлсэн.	100%

10.3.1 Усны хими, физикийн ерөнхий шинжилгээ

Химийн бүрэлдэхүүнээрээ холимог ангийн, натрийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд НБҮ худаг нь давсархаг, зөөлөн ус, ТТЗ худаг нь цэнгэгдүү, зөөлөн, төмөртэй ус байна. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018 стандартад заасан хэмжээнээс НБҮ худгийн ус нь нийт эрдэсжилт, натрийн ионы агууламж их, ТТЗ худгийн натрийн ион, төмрийн агууламж бага зэрэг их байна.



Зураг № 46. Усны ерөнхий химийн шинжилгээний дээж авч буй байдал

Хүснэгт № 24. Ашиглалтын худагуудын усны химийн шинжилгээний дүн

Он сар	Байршил	pH	Кали,натри	Кальци	Карбонат	Магни	Гидрокарбона Т	Ниграт	Төмөр	Нигрит	Сульфат	Хлорид	Аммони	Хатуулаг	Исэлдэх чадвар	Хуурай үлдэгдэл	Булингаршилт	Цахилгаан дамжуулах чадвар	Цахиурын хэмжээ
2024.01.31	Баяжуулах шүүрлийн ус	7.7		7.014		22.17								0.5		1143		2.241	
		1.8	5.982	23.8	18	15.2	231.8	8	4	1	175	167.2	0.2	2.44	2.24	746		1243	
2024.03.11	НБУ худаг	9.08	8.817	32.1	24	18	366	10	0.3	1	390	305.3	0.2	3.08	2.24	1386	1.18	2310	
		7.94	252.1	24.8	12	17.8	256.2	14	0	0	196	168.6	0	2.7	1.92	798		1330	
2024.07.29	НБУ худаг	7.96	489.1	29.1	12	20.4	402.6	18	0.5	0.1	395	316	0	3.13	5.44	1380		2300	
		8.3	33.7	6	16.53	405.7	0.52	0.05	0.05	340.8	309.7	0.1	0.1	3.04	4.6	1392	10	2185	10.51
2024.09.09	НБУ худаг	8.26		27.34	4.5	14	262.4	1.07		0.05	165.5	166.7	0.1	2.52	1.6	762	10	1253	12.34
		7.94	252.1	24.8	12	17.8	256.2	14	0	0	196	168.6	0	2.7	1.92	798		1330	

10.3.2 Усны хүнд металлын шинжилгээ

Нүүрс баяжуулах үйлдвэрийн орчмоос бетон зуурмагийн үйлдвэр, түр оффис, нүүрс баяжуулах үйлдвэрийн худаг болон хадан усны /малчны/ худаг зэрэг байршилд усны шинжилгээнд зориулж дээж авсан. Тухайн дээжүүдэд усны хүнд металлын шинжилгээг хийсэн.



Зураг № 47. Усны дээж цуглуулалт

Хүснэгт № 25. Шинжилгээний хариу

Он сар	Байршил	Фосфат	Фотр	Бромид	Үлдэгдэл хлор	Кадми	Хром	Зэс	Төмөр	Никель	Хартунгалга	Цайр
		мг/кг										
2024.09.09	НБУ худаг	0.06	2.65	0.41	0.1	0.001	0.005	0.02	0.07	0.005	0.01	0.01
	ТТЗ худаг	0.09	2.77	0.16	0.1	0.001	0.005	0.02	0.08	0.005	0.01	0.01

10.3.3 Микробиологийн шинжилгээ

Төслийн үйл ажиллагаанд ашигладаг 2 худаг /НБУ худаг, ТТЗ худаг/, малчны 1 худаг /Хадан усны худаг/-аас дээж авч Өмнөговь аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн лабораторид шинжлүүлсэн.



Зураг № 48. Усны микробиологийн шинжилгээний дээж бэлтгэсэн байдал

Хүснэгт № 26. Шинжилгээний хариу

Он сар	Байршил	Бактерийн ерөнхий тоо	Колиформ	Салмонелла	Колиформ гэдэсний бүлгийн нянгийн тоо


2024.04.04	НБҮ худаг	300	-	0	0
	ТТЗ худаг	251	-	0	0
2024.09.09	ТТЗ худаг	12	0	0	0
	НБҮ худаг	17	0	0	0

10.4 Ургамлан бүрхэвчийн хяналт, шинжилгээ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
10.4.1	Ургамлын мониторинг	15 цэгт жилд 1 удаа	Тайлант онд төслийн талбайгаас гадагш салхины зонхилох чиглэл дор 10-15км-ийн зайд ургамлын мониторингийг хийж гүйцэтгэсэн.	100%

10.4.1 Ургамлын мониторинг

Ургамлын мониторингийн судалгааын ажлыг 2024 оны 10 сарын 05-ны өдөр Нүүрс баяжуулах үйлдвэрээс 10-15 км-ын зайтай салхин дор байрлах цэгийг сонгог 9 н цэгт нийт 27 удаагийн давтамжтайгаар хийж гүйцэтгэлээ.



Ургамлын мониторингийн байршлын зураг

Хүснэгт № 27. Ургамлын бичиглэл-1

Ургамлын бүлгэмдлийн, төрөл: Монгол өвс-улаан бударганат
Координат: Y – 105° 42' 53" X – 43° 36' 50"



Хүснэгт № 28. Зонхилох ургамлын нэрс

Зонхилох ургамал	Арви	Өндөр /см/	Хөгжлийн үе шат
Таана /Allium polyrrhizum/	Cop1	2-12	Бутлалт
Монгол өвс /Stipa glareosa/	Sp	2-10	Бутлалт
Зүүнгарын улаан бударгана /Reaumuria soongarica/	Sp	2-20	Бутлалт
Үслэг манан хамхаг	Cop1	2-30	Бутлалт

Бэлчээр хадлангийн ангилалаар монгол өвс улаан бударганат ургамлыг бүлгэмдэлд орох бөгөөд Таана /Allium polyrrhizum/, Үслэг манан хамхаг зэрэг ургамал 10-25%-иар Cop1 арвитайгаар, Монгол өвс /Stipa glareosa/, Зүүнгарын улаан бударгана /Reaumuria soongarica/ зэрэг ургамал 5-10%-ийн бүрхэцтэй Sp арвитай тохиолдоно. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 1м² талбайд 15%, ургамлын дундаж өндөр 2-20. см, зүйлийн тоо

Хүснэгт № 29. Ургамлын бичиглэл-2

Ургамлын бүлгэмдлийн, төрөл: Монгол өвс-таанат
Координат: Y – 105° 45' 5" X – 43° 59' 15"



Хүснэгт № 30. Зонхилох ургамлын нэрс

Зонхилох ургамал	Арви	Өндөр /см/	Хөгжлийн үе шат
Ахар навчит баглуур /Anabasis brevifolia/	Sp	2-10	Бутлалт
Бор бударгана /Salsola passerina/	Sp	2-30	Бутлалт
Таана /Allium polyrrhizum/	Cop1	2-12	Бутлалт
Монгол өвс /Stipa glareosa/	Cop1	2-15	Бутлалт

Бэлчээр хадлангийн ангилалаар монгол өвс-таанат ургамлыг бүлгэмдэлд орох бөгөөд Ахар навчит баглуур /*Anabasis brevifolia*/, Бор бударгана /*Salsola passerina*/, Таана /*Allium polyrrhizum*/, Монгол өвс /*Stipa glareosa*/, Зүүнгарын улаан бударгана /*Reaumuria soongarica*/ зэрэг ургамал 5-10%-ийн бүрхэцтэй Sp арвитай тохиолдоно. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 1м² талбайд 18%, ургамлын дундаж өндөр 2-30. см, зүйлийн тоо 4.

Хүснэгт № 31. Ургамлын бичиглэл-3

Ургамлын бүлгэмдлийн, төрөл: Монгол өвс-таанат
Координат: Y – 105° 46' 59" X – 43° 34' 9"



Хүснэгт № 32. Зонхилох ургамлын нэрс

Зонхилох ургамал	Арви	Өндөр /см/	Хөгжлийн үе шат
Ахар навчит баглуур / <i>Anabasis brevifolia</i> /	Sp	2-8	Бутлалт
Харлаг өмхий өвс / <i>Peganum nigellastrum</i> /	Sp	2-12	Бутлалт
Таана / <i>Allium polyrrhizum</i> /	Сор1	2-12	Бутлалт
Монгол өвс / <i>Stipa glareosa</i> /	Sp	2-10	Бутлалт

Бэлчээр хадлангийн ангилалаар монгол өвс-таанат ургамлыг бүлгэмдэлд орох бөгөөд Таана /*Allium polyrrhizum*/ зэрэг ургамал 10-25%-ийн бүрхэцтэй Сор1 арвитайгаар Ахар навчит баглуур /*Anabasis brevifolia*/, Харлаг өмхий өвс /*Peganum nigellastrum*/, Таана /*Allium polyrrhizum*/, Монгол өвс /*Stipa glareosa*/, Зүүнгарын улаан бударгана /*Reaumuria soongarica*/ зэрэг ургамал 5-10%-ийн бүрхэцтэй Sp арвитай тохиолдоно. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 1м² талбайд 15%, ургамлын дундаж өндөр 2-12. см, зүйлийн тоо 4. Дундаж ургац 0.4 га байна.

Хүснэгт № 33. Ургамлын бичиглэл-4

Ургамлын бүлгэмдлийн, төрөл: Монгол өвс-хазаар өвст
Координат: Y – 105° 46' 59" X – 43° 34' 9" N



Хүснэгт № 34. Зонхилох ургамлын нэрс

Зонхилох ургамал	Арви	Өндөр /см/	Хөгжлийн үе шат
Ахар навчит баглуур /Anabasis brevifolia/	Sp	2-8	Бутлалт
Хуурайсаг шарилж /Artemisia herophytica/	Sp	2-15	Бутлалт
Зүүнгарын хазаар өвс /Cleistogenes songorica/	Sp	2-12	Бутлалт
Таана /Allium polyrrhizum/	Сор1	2-12	Бутлалт
Монгол өвс /Stipa glareosa/	Sp	2-10	Бутлалт

Бэлчээр хадлангийн ангилалаар Монгол өвс-хазаар өвст ургамлыг бүлгэмдэлд орох бөгөөд Таана /Allium polyrrhizum/ зэрэг ургамал 10-25%-ийн бүрхэцтэй Сор1 арвитайгаар Ахар навчит баглуур /Anabasis brevifolia/, Хуурайсаг шарилж /Artemisia herophytica/, Зүүнгарын хазаар өвс /Cleistogenes songorica/, Монгол өвс /Stipa glareosa/, Зүүнгарын улаан бударгана /Reaumuria songarica/ зэрэг ургамал 5-10%-ийн бүрхэцтэй Sp арвитай тохиолдоно. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэц 1м² талбайд 16%, ургамлын дундаж өндөр 2-15. см, зүйлийн тоо 5.

10-р сард ургамлын бүрхэц 1м² талбайд 3-5% -н бүрхэцтэй байсан. Ургамлан нөмрөг өндөр 2-30 см өндөр ургасан.

10.5 Амьтны аймгийн мониторинг

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
10.5.1	Амьтны мониторинг	4 цэгт жилд 1 удаа	Нүүрс баяжуулах үйлдвэрийн БОМТ-г хэрэгжүүлэх ЭТТ-2024/1397 тоот гэрээний дагуу “Ийрт Плас” ХХК-ийн биологийн мэргэжилтэнтэй хамтран Цогтцэций сумын Сийрс багийн нутагт байрлах Тугийн цохио, Билгэх багийн нутагт байрлах Хангинахын хаданд амьтны камер байршуулж амьтны суурь судалгааг хийж гүйцэтгэсэн.	100%

10.5.1 Амьтны мониторинг

Нүүрс баяжуулах үйлдвэрийн БОМТ-г хэрэгжүүлэх ЭТТ-2024/1397 тоот гэрээний дагуу “Ийрт Плас” ХХК-ийн биологийн мэргэжилтэнтэй хамтран Цогтцэций сумын Сийрс багийн нутагт байрлах Тугийн цохио, Билгэх багийн нутагт байрлах Хангинахын хаданд амьтны камер байршуулж амьтны суурь судалгааг хийж гүйцэтгэсэн.

Хүснэгт № 35. Автомат камерын байршил

№	Харьяалагдах аймаг сум	Газрын нэршил	Солбицол	
			N	E
1	Өмнөговь аймгийн Цогтцэций сум	Тугийн цохио	4843008.36	588391.28
2		Хангинах уул	4834719.70	577195.01
3		Хангинах уул	4834722.05	577080.79


Монгол оронд өнөөдрийн байдлаар 140 зүйлийн хөхтөн амьтан бүртгэгдээд (Батсайхан нар 2022) байгаа бол өмнөд говийн тойрогт 33 зүйл (Банников, 1954), харин таван толгойн ордын орчимд 22 зүйл хөхтөн амьтад бүртгэгдээд байна. Үүний дотор аргаль хонь, янгир ямаа, хар сүүлт зээр, цагаан зээр, хулан адуу зэргийг дурдаж болно.

Хээрийн судалгааг туруутан амьтад тохиолдох боломжтой газруудад харууц цэг сонгох, мөн шугаман замналын аргаар автомашинаар болон явганаар явж ажиглалт, бүртгэл хийсэн болно. Мэрэгч амьтдын судалгаанд [Sherman \(https://shermantraps.com/\)](https://shermantraps.com/) загварын 40 ш амьд баригчийг мөр хооронд 10 метрийн зайтайгаар 400 метр талбайд байрлуулж өгөөшинд самрын тос, будаа зэргийг ашиглалаа.

Хээрийн судалгаагаар Хангинахын ам орчимд 2 аргаль хонь, 6 янгир ямаа, 60 гаруй цагаан зээрийн сүрэг бүртгэгдсэн бол Тугийн цохио орчимд мөн 11 тооны янгир ямааг бүртгэж баримтжууллаа. Бусад хөхтөн амьтаас бор туулай, монгол чичүүл, улбар шанаа зурам, үнэг, хярс зэрэг амьтдыг бүртгэж баримтжуулсан болно

Хүснэгт № 36. Хөхтөн амьтны зүйлийн жагсаалт, хамгааллын статус, тоо толгой, тархалт

№	Зүйлийн нэр	Улаан дансны үнэлгээ	Бүс нутгийн үнэлгээ	Тоо толгой, байршил
1	Аргаль хонь	ХБ	УБ	Хангинахын ам, түүнээс урагш Бичигт хад хүртэл тархана, тоо толгой 10 орчим
2	Янгир ямаа	АӨ	ХБ	Хангинахын ам, Тугийн цохио орчимд, тоо толгой 60 орчим
3	Цагаан зээр	УБ	АӨ	Цогтцэций сумаас Хангинахын ам чиглэлд цөөн таарсан бол Хангинахын ам орчимд 60 гаруй амьтантай сүрэг
4	Үнэг	АӨ	ХБ	Хангинах
5	Хярс	АӨ	ХБ	Хангинах, Тугийн цохио
6	Бор туулай	АӨ	АӨ	Тугийн цохио орчимд 1 бодгаль
7	Улбар шанаа зурам	АӨ	АӨ	Цогтцэций сумаас Хангинахын ам явах зам дагуу
8	Монгол чичүүл	АӨ	АӨ	Хангинахын ам орчимд зөөлөн хөрстэй, сайр дагуу
9	Сибирь алаг даага	АӨ	АӨ	Эдгээр зүйлүүд нь өвөл ичээлдэг бөгөөд дүйцүүлэн хамгаалах талбайн зөөлөн хөрстэй, сайрууд, хөндий, уулын хээрт түгээмэл тохиолдоно.
10	Говийн алагдаага	АӨ	АӨ	
11	Савагдаахай	АӨ	АӨ	
12	Элсний зусаг	АӨ	АӨ	



Зураг № 49. Хээрийн судалгаа хийсэн замнал болон автомат камерын байршил



Зураг № 50. 2024 оны 09 сарын 17 Янгир ямаа, Тугийн цохио орчимд,
Цагаан зээрийн сүрэг, Хангинахын хад орчимд

Хээрийн судалгаагаар багт хамаарах 30 зүйлийн шувуудыг бүртгэсэн бөгөөд түүний Судалгааны талбайд бүртгэгдсэн зүйлүүдээс 17 буюу 56 хувь нь суурин, 13 буюу 43 хувь нь нүүдлийн зүйл байна.

Хүснэгт № 37. Шувуудын зүйлийн жагсаалт болон оршин амьдрах хэлбэр

№	Зүйлийн Монгол нэр	Зүйлийн шинжлэх ухааны нэр	Цогтцэций сумын төв орчим	Хангинахын хад орчим	Оршин амьдрах статус
GALLIFORMES-ТАХИА					
1	Эрээн хавирга хахилаг	<i>Alectoris chukar</i>			Суурин
ACCIPITRIFORMES-ХАРЦАГА					
2	Нөмрөг тас	<i>Aegypius monachus</i>			Суурин
3	Саарал хулд	<i>Circus cyaneus</i>			Нүүдлийн

4	Ооч ёл	<i>Gypaetus barbatus</i>			Суурин
5	Шилийн сар	<i>Buteo hemilasius</i>			Суурин
PASSERIFORMES-БОР ШУВУУ					
6	Хон хэрээ	<i>Corvus corax</i>			Суурин
7	Хар хэрээ	<i>Corvus corone</i>			Суурин
8	Алаг шаазгай	<i>Pica pica</i>			Суурин
9	Алагтуу хэрээ	<i>Coloeus dauuricus</i>			Нүүдлийн
10	Дэрсний жиргэмэл	<i>Alaudala cheleensis</i>			Суурин
11	Монгол болжмор	<i>Melanocorypha mongolica</i>			Суурин
12	Эвэрт болжмор	<i>Eremophila alpestris</i>			Суурин
13	Науманны хөөндэй	<i>Turdus naumanni</i>			Нүүдлийн
14	Хар гүеэт хөөндэй	<i>Turdus atrogularis</i>			Нүүдлийн
15	Жирхэн дууч шувуу	<i>Phylloscopus proregulus</i>			Нүүдлийн
16	Хөх зоот гургалдай	<i>Tarsiger cyanurus</i>			Нүүдлийн
17	Дагуур галсүүлт	<i>Phoenicurus aureoreus</i>			Нүүдлийн
18	Тагийн хайруулдай	<i>Prunella collaris</i>			Суурин
19	Шарга хайруулдай	<i>Prunella fulvescens</i>			Суурин
20	Хадны бор шувуу	<i>Petronia petronia</i>			Суурин
21	Хээрийн бор шувуу	<i>Passer montanus</i>			Суурин
22	Харзны шийхнүүхэй	<i>Anthus spinoletta</i>			Нүүдлийн
23	Дуулгат бужирга	<i>Fringilla coelebs</i>			Нүүдлийн
24	Бор цэгцүүхэй	<i>Linaria flavirostris</i>			Нүүдлийн
25	Годлевскийн хөмрөг	<i>Emberiza godlewskii</i>			Суурин
26	Хар шанаат хөмрөг	<i>Emberiza rustica</i>			Нүүдлийн
27	Талын үнсэн дунхай	<i>Lanius pallidirostris</i>			Нүүдлийн
28	Бөөвөлжин өвөөлж	<i>Upupa epops</i>			Нүүдлийн
PTEROCLIFORMES-НОГТРУУ					
29	Монгол ногтруу	<i>Syrhaptes paradoxus</i>			Суурин
COLUMBIFORMES-ТАГТАА					
30	Хадны тагтаа	<i>Columba rupestris</i>			Суурин

Хээрийн судалгаагаар Хангинахын уул, түүний орчимд 3 зүйлийн гүрвэл (цоохор хонин гүрвэл, монгол гүрвэл, говийн гүрвэл) бүртгэгдсэн байна. Үүнээс цоохор хонин гүрвэл тоо толгойн хувьд хамгийн элбэг, бүхий л амьдрах орчинд тохиолдох бол, монгол гүрвэл зөвхөн бэсрэг уулсын хад, асгатай газарт цөөн, говийн гүрвэл уулын хээр, жалга, судаг дагуу цөөн тохиолдоно.

Энэ бүс нутагт 2 зүйл могой (рашааны болон бамбай хоншоорт) түгээмэл тохиолдох бөгөөд эдгээр мөлхөгчид нь бүс нутгийн болоод Олон улсын хэмжээнд анхааралд өртөхөөргүй гэж үнэлэгдсэн, хэвийн зүйл юм.

11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
11.1	Байгаль хамгаалах ажлын барьцаа хөрөнгө төвлөрүүлэх	ТЖБОМТ-д тусгасан Зардал	БОМТ-ний барьцаа хөрөнгийн 50% буюу 157.25 сая төгрөгийг байгаль орчны тусгай санд байршуулсан.	100%
11.2	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайланг ажлын хэсгээр дүгнүүлэх	-	Хугацаа болоогүй.	

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
11.3	Жил бүрийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах	-	НБҮ-ийн төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-аар батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан.	100%
11.4	Байгаль орчны хууль, журам, стандартын хэрэгжилтийг хангах зорилгоор байгаль Орчны дотоод хяналтыг хэрэгжүүлэх	Тухай бүрд	Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын журам, Газар хөндөх журам, Өнгөн хөрстэй ажиллах журам, Асгаралтын эсрэг авах арга хэмжээний журам, ХАБЭА, Байгаль орчны зөрчил, зөрчилд авах хариу арга хэмжээний журмуудыг тус тус боловсруулж, батлуулсан.	100%

11.1 Байгаль хамгаалах ажлын барьцаа хөрөнгө төвлөрүүлэх

Нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний барьцаа хөрөнгийг Төрийн сангийн 1009000013406 тоот дансанд 2024 оны 01-р сарын 16-ны өдөр төвлөрүүлсэн.

ТӨЛБӨРИЙН ДААЛГАВАР				Санхүү Эдийн засгийн сайд, Үндэсний Статистикийн Газрын даргын 2002 оны 6-р сарын 18-ны өдрийн 171/111 тоот тушаалын хэвсрэлт	
№: ХЗ-15-0040				2024.01.16	
Төлөгчийн нэр: “Эрдэнэс Тавантолгой” ХК					
Хүлээн авагч: БО нөхөн сэргээх баталгаа				Данс	Дүн
Төлөгчийн банк	Төрийн банк	Дебит данс	346502273740	157,258,800.00	
Хүлээн авагчийн банк	Төрийн сан	Кредит данс	100900013406		
Мөнгөн дүн (үсгээр)	Нэг зуун тавин долоон сая хоёр зуун тавин найман мянга найман зуун төгрөг			... хоног торгууль ... төг ... мөн	
Барааг хүлээн авсан буюу ажил үйлчилгээ гүйцэтгэсэн: 2024.01.16				Дүн (торгуультай)	
Төлбөрийн зориулалт:				Гүйлгээний утга	
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний барьцаа хөрөнгө - ЭТХ ХК-ийн Нүүрс баяжуулах үйлдвэр				Төлбөрийн зориулалт	
				Төлөх	
				Төлбөрийн ээлж	
 Онцгой бүрэн эрхт төлөвлөгч Тамга Ерөнхий нягтлан бодогч				 Банкнд гүйлгээ хийсэн огноо: 2024 он . . . сар . . . өдөр Гарын үсэг:	


Зураг № 51. Төлбөр төлсөн баримт.

11.2 Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайланг ажлын хэсгээр дүгнүүлэх

Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Өмнөговь аймгийн Засаг даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг газар дээр нь ирж ажиллаж дүгнэдэг бөгөөд энэ ажлын хэсэг нь 11-р сарын дундуур ирж ажилладаг тул хугацаа болоогүй байна.

11.3 Жил бүрийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах

Нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 01-р сарын 08-ны өдөр БОАЖЯ-ны цахимд байршуулсан. 2024 оны 02-р сарын 22-ны өдөр БОУАӨЯ-ны ахлах шинжээч томилогдож төлөвлөгөөг хянаад 2024 оны 03-р сарын 26-ны өдөр батлуулсан.



Зураг № 52. Батлагдсан 2024 оны БОМТ-ний нүүрний зураг

11.4 Байгаль орчны хууль, журам, стандартын хэрэгжилтийг хангах зорилгоор байгаль орчны дотоод хяналтыг хэрэгжүүлэх

Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын журам, Газар хөндөх журам, Өнгөн хөрстэй ажиллах журам, Асгаралтын эсрэг авах арга хэмжээний журам, ХАБЭА, Байгаль орчны зөрчил, зөрчилд авах хариу арга хэмжээний журмуудыг тус боловсруулж, батлуулсан. Эдгээр журмын хэрэгжилтийг өдөр тутамдаа хангаж ажилладаг ба тайлант онд Нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтэц орон тооны төлөвлөгөөнд Баяжуулах үйлдвэр хариуцсан байгаль орчны инженерийн 2 орон тоог суулган батлуулсан.

Мөн ажилтнуудын Байгаль хамгаалах хүсэл зорилгыг дэжих зорилгоор ажилтнуудын дунд уралдаан тэмцээн зохион байгуулах замаар байгаль орчныг хамгаалах идэвхийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.



Зураг № 53. Ажилтнуудын дунд АХА тэмцээн зохион байгуулж буй байдал

Дэлхийн усны өдрийг тохиолдуулан төслийн нийт ажилчдын дунд танин мэдэхүйн сургалт орж, АХА тэмцээнийг зохион байгуулсан. Нийт 60 ажилтан оролцсон.



Зураг № 54. Дэлхийн усны өдрийг тохиолдуулан зохион байгуулсан “Усны уулзалт” хэлэлцүүлэг

12. НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
12.1	Сумын иргэд	1-р улиралд БОМТ-н биелэлт танилцуулах	2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Цогтцэций сумын 20 иргэнд бүтээн байгуулалтын явц, байгаль орчны талаар мэдээлэл хийж, танилцуулсан.	100%
12.2	Нөлөөллийн бүсийн иргэд, сумын удирдлага, мэргэжилтэнүүд	Жилд 1 удаа үйл ажиллагаа танилцуулах	2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр нөлөөллийн бүсийн 33 иргэнд үйлдвэрийн бүтээн байгуулалт, байгаль орчны талаар мэдээлэл, танилцуулга хийсэн. Сум орон нутгийг дэмжиж өвөлжилтийг өнтэй давахад Өмнөговь аймгийн ЗДТГ-т 20,0 сая, Цогтцэций сумын малчдад 17,0 сая, Цогтцэций сумын 100 жилийн баярт 25,0 сая, Цэций хайрханы тахилгад 5,0 сая, Эрүүл мэндийн төвд 4,0 сая, Онцгой байдлын хэлтэст 3,0 сая төгрөгийн, Цагдаагийн хэлтэст 500,0 мянган төгрөгийн бараа материал, Онцгой байдлын хэлтэст 40 м3 бетон зуурмагийн дэмжлэг үзүүлсэн.	100%

12.1 Сумын иргэдэд БОМТ-н биелэлт танилцуулах

2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Цогтцэций сумын 20 иргэнд бүтээн байгуулалтын явц, байгаль орчны талаар мэдээлэл хийж, танилцуулсан.



Зураг № 55. Цогтцэций сумын иргэдэд төслийн бүтээн байгуулалт, байгаль орчны талаар мэдээлэл, танилцуулга хийж буй байдал

12.2 Нөлөөллийн бүсийн иргэд, сумын удирдлага, мэргэжилтэнүүдэд үйл ажиллагааг танилцуулах

2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр нөлөөллийн бүсийн 33 иргэнд үйлдвэрийн бүтээн байгуулалт, байгаль орчны талаар мэдээлэл, танилцуулга хийсэн.



Зураг № 56. Цогтцэций сумын иргэдэд төслийн бүтээн байгуулалт, байгаль орчны талаар мэдээлэл, танилцуулга хийж буй байдал

Сум орон нутгийг дэмжиж өвөлжилтийг өнтэй давахад Өмнөговь аймгийн ЗДТГ-т 20,0 сая, Цогтцэций сумын малчдад 17,0 сая, Цогтцэций сумын 100 жилийн баярт 25,0 сая, Цэций хайрханы тахилгад 5,0 сая, Эрүүл мэндийн төвд 4,0 сая, Онцгой байдлын хэлтэст 3,0 сая төгрөгийн, Цагдаагийн хэлтэст 500,0 мянган төгрөгийн бараа материал, Онцгой байдлын хэлтэст 40 м3 бетон зуурмагийн дэмжлэг үзүүлсэн.



Зураг № 57. Сум орон нутагт дэмжлэг үзүүлж буй байдал

13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

№	Үйл ажиллагааны чиглэл	Төлөвлөсөн төсөв	Зарцуулсан хөрөнгө /мян. ₮/
1	Нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа	173,900.00	85,083.00
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	47,400.00	47,400.00
3	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	11,000.00	11,000.00
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	55,500.00	55,500.00
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	17,117.60	17,117.00
6	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	8,000.00	8,000.00
7	Оршин суугч, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө	1,600.00	-
Нийт		314,517.60	224,100.00

14. ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР

Бүлэг	Бүлгийн нэр	Төлөвлөсөн ажил	Шалгуур	Хэрэгжилт	Хувь	Эзлэх жин
6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө						
6.1.1	Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах чиглэлээр	Зам талбайг усалж тоосжилтыг дарах	Тоосны түвшинг хамгийн бага байлгах түвшинд усалгааг хийнэ.	Барилга болон замын ажлын үед үүсэх тоосжилт дарах усалгаанд 1019 м3 усыг ашигласан.	100%	1
6.1.2		Цэвэрлэх байгууламжтай ААН-д гэрээгээрээ шингэн хаягдлаа нийлүүлэх	Зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан байна.	Төслийн хэмжээнд 3 бохирын цэгтэй ба тус цэгүүд септик танк болон кольцогоор хийгдсэн. Хэрэглээнээс гарсан 504 м3 саарал усыг “Арцат шанх” ХХК-тай гэрээ байгуулж цэвэрлэх байгууламжинд нийлүүлж 21.560 сая төгрөгийг төлсөн байна.	100%	1
6.1.3		Хаягдлын овоолгын усалгаа хийж дагтаршуулах	Хаягдлын овоолгод усалгаа хийж дагтаршуулсан байна.	Баяжуулах үйл ажиллагаа эхлээгүй байгаа тул одоогоор хаягдал гараагүй байна.	100%	1
6.2.1	Газрын гадаргад үзүүлэх нөлөөллийг бууруулах чиглэлээр	Өнгөн хөрсний овоолгыг 2 жил ашиглахгүй бол стандартын дагуу хадгалах	Өнгөн хөрстэй ажиглах журмын дагуу хуулж хадгалсан байна.	MNS5916:2008 “Газар шорооны ажлын үед шимт хөрс, хуулалт хадгалалт” стандарт, NOR-HSE-ENV-PRC-003-0 Өнгөн хөрстэй ажиглах журмын дагуу 1 м өндөртэй овоолго үүсгэж, хэлбэршүүлэлт хийж, хадгалсан.	100%	1
6.2.2		Тусгай зөвшөөрөл бүхий ААНБ-аас ТТАМ-ийг ашиглах, гэрээ, бичиг баримтын бүрдлийг хангах	Бүх бичиг баримтын бүрдлийг бүрэн хангана.	Бетон зуурмагийн үйлдвэрт тусгай зөвшөөрөл бүхий “Өгөөмөр гавилууд” ХХК, “Өсөх говь” ХХК-аас тус тус 21,406.2 м3 хайрга, дайрга, “Сауд гоби капитал” ХХК-аас 16,950 м3 элс татан авсан.	100%	1
6.2.3		Замын маршрутын батлуулж зөвхөн батлагдсан маршрутаар зорчих.	Сумын цагдаагийн газраар маршрут батлуулан мөрдүүлж ажиллана.	Цогтцэций сумын Засаг даргын 2023 оны А/140 дүгээр захирамжаар Цогтцэций сум – НБҮ төслийн талбай хүртэлх замын маршрут, 2023 оны А/311 дүгээр захирамжаар ТТГС хатуу хучилттай автозамын 4 дэх км-ээс НБҮ төслийн талбай хүртэлх замын маршрутыг тус тус батлуулж, тээврийн хэрэгслүүд зорчиж байна.	100%	1

6.2.4		Эвдрэлд өртсөн талбайг байгалийн унган төрхөд дөхүүлэн хэлбэршүүлэх	Эвдрэлд өртсөн талбайг байгалийн унган төрхөд дөхүүлэн хэлбэршүүлсэн байна.	Үйлдвэрийн барилга байгууламж, шугам хоолой газар шорооны үед өртсөн газруудыг байгалийн унаган төрхөнд нь дөхүүлэн хэлбэршүүлсэн.	100%	1
6.3.1	Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	Бохир ус цэвэрлэх байгууламж байгуулах.	Төслийн талбайд стандартын шаардлага хангасан 1 ширхэг цэвэрлэх байгууламж байгуулсан байна.	Шинээр байгуулагдаж буй оффис ажилчдын хотхонд шинээр цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил хийгдсэн.	100%	1
6.3.2		Хог хаягдлын түр цэгт тогтмол хяналт тавьж ажиллах	Тогтмол хяналт тавьж ажилласан байна.	Хог хаягдлын түр цэгийн хог хаягдлыг 7 хоногт 4 удаа тогтмол ачиж байна.	100%	1
6.3.3		Шимт хөрсний овоолгыг нимгэн материалаар хучиж хадгална	20000 м ² -аас багагүй талбайг нимгэн материалаар хучсан байна.	Нүүрс баяжуулах үйлдвэрийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх ажлын төсвийн компанийн 2024 оны төсөвт суулган батлуулж уг төсвийн хүрээнд тендер шалгаруулалт зарлаж “Ийрт Плас” ХХК шалгарч ажил хийж байна. Уг гэрээний ажлын даалгаварт шимт хөрсний удаан хугацаагаар хадгалагдах 5000 м ³ овоолгыг агаар нэвтрүүлдэг нимгэн материалаар хучиж цаг агаарын эрсдэлээс сэргийлэх ажлыг тусгасан.	100%	1
6.3.4		Химийн бодисын сав баглаа боодлын хаягдлын талбайг байгуулах	Стандартын шаардлага хангасан талбайг 2500 м ² талбайд байгуулсан байна.	Хог хаягдлын тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу Аюултай хог хаягдлын цэгийг байгуулсан.	100%	1
6.4.1	Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, ус ашиглах гэрээ байгуулах, төлбөрийг тогтмол хугацаанд төлөх	Ус ашиглах дүгнэлт гаргуулж гэрээ байгуулан төлбөрийг бүрэн төлж барагдуулсан байна.	Төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй 2 худгийг Ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл авч, гэрээ байгуулан зөвшөөрлийн дагуу ашиглаж байна.	100%	2

6.4.2		Худагт бохирдол алдагдахаас сэргийлэх, холбогдох шаардлага, стандартын дагуу худгийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байгаа эсэхэд тогтмол хяналт тавина.	Тогтмол хяналт тавьж ажилласан байна.	Худгийн үйл ажиллагаа, тоолуурын хэвийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавин ажиллаж байна. 2024 оны 10-р сарын байдлаар НБҮ, ТТЗ худгаас 15,418 м3 усыг ашигласан байна.	100%	2
6.5.1	Амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг бууруулах чиглэлээр сөрөг	Кемп болон НБҮ-ийн ойр орчимд харагдаж буй амьтдыг тэмдэглэх	Тэмдэглэл хөтөлсөн байна.	НБҮ-ийн кемп болон ойр орчим ажиглагдсан амьтдын бүртгэлийн хуудсыг гарган бүртгэсэн. Нийт 5-9 сарын хугацаанд 11 төрлийн 430 гаруй амьтан ажиглагдсан байна.	100%	2
6.5.2		Хөнжлийн нуруунд амьтдын нүүдлийн трассуудыг тогтоох, камержуулах /аргал болон цагаан зээр очих магадлалтай нутаг/	2 байрлалд автомат камер байрлуулна.	Цогтцэций сумын Тугийн цохио, Хангинах нэртэй газруудад 3 цэгт зэрлэг амьтны ажиглалтын камерийг суурилуулсан. Ажиглалтын камераар Тугийн цохио орчим 2 янгир ажиглагдсан.	100%	3
					100%	20
7. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө						
7.1.1	Ажиллагсадын түр кемпын орчим 0.01 га- д мод тарих	Ногоон байгууламж нэмэгдүүлэх зорилгоор модлог ургамлыг тарих, арчлах	5000 ширхэг модлог ургамлыг тарьж арчилна.	2024 оны 5 сард 5000 /хайлаас 4500, голт бор 500/ ширхэг тарьц, суулгацыг тариалж, усалгааг арчилгааг тогтмол зохион байгуулж байна. Мөн Иргэний барилга орчмын ногоон байгууламжийн тохижилтын ажлыг “Аму грийн гарден” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.	100%	30
					100%	30
8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө						
8.1.1	Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр	Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах	Урьдчилсан мэдээллийг тогтмол авч үйл ажиллагаанд ашиглах.	Цаг агаарын 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглаж байна. Гэрээт компаниудад албан майл болон viber апп-аар дамжуулж мэдээллийг хүргүүлэн ажилласан.	100%	3
8.1.2		Гамшгийн эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх	Мэргэжлийн байгууллагаар эрсдэлийн үнэлгээг хийлгэж үйл	Нүүрс баяжуулах үйлдвэрийн Гамшгийн эрсдэлийн үнэлгээг “Гамшгаас хамгаалах судалгаа шинжилгээний үндэсний төв”-өөр гүйцэтгүүлсэн.	100%	3

			аижллагаанд мөрдлөгө болгон ажиллана.			
8.1.3		Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	Улирал тутас 50-иас багагүй хүнд сургалт орж мэдлэг олгосон байна.	Цогтцэций сумын Онцгой байдлын хэлтэстэй хамтран Галын аюулгүй байдлын танхим, практик хосолсон сургалтыг 3 сард зохион байгуулсан. Танхимийн сургалтанд 88 хүн, практик сургалтанд хийт 150 хүн хамрагдсан.	100%	3
8.1.4		Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах	Галын сараа, гал унтраагуурыг хангалттай хэмжээгээр байрлуулсан байна.	Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг MNS5566:2020 стандартын дагуу бүрдүүлж, бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Гэр кэмпэд галын хор болон утаа мэдрэгчдийг байршуулсан.	100%	3
8.2.1	Үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	Нэг бүрийн хамгаалах хэрэгслийн хэрэглээнд байнгын хяналт хийж ажиллана.	Төслийн хэмжээнд ХАБЭА-н 10 журам батлуулж мөрдүүлсэн. Өдөр тутмын тойрох үзлэгээр журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд зөрчлийн бүртгэл, тойрох үзлэгийн бүртгэл хөтөлж байна. Сайтад тохиолдсон аюултай тохиолдол ослыг судлан бүртгэх, сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан гүйцэтгэлийг бүртгэлжүүлсэн.	100%	3
					100%	15
9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө						
9.1.1	Ахуйн хог хаягдал	Ахуйн гаралтай хог хаягдлыг ангилан ялгаж дахин ашиглах, зайлуулах арга хэмжээнүүдийг тодорхойлох	Ахуйн гаралтай хог хаягдлыг ангилан ялгаж дахин ашиглах, зайлуулах арга хэмжээ авна.	Дахивар бүтээгдэхүүн цуглуулах “Дүүрэн тохижилт” ХХК-д 40 тн хуванцар хог хаягдлыг хүлээлгэн өгсөн. Орон нутгийн “Нутгийн ариун зам” ХХК-тай хог хаягдлын цэвэрлэх, тээвэрлэх гэрээг байгуулж 2024 оны 4 сараас эхлэн 2 техник, 40 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.	100%	3
9.1.2		Дотоод, гадаад орчны хог цуглуулах савны стандартыг сайжруулах.	Хогын савны стандартуудыг сайжруулсан байна.	НБҮ-ийн оффис, гэр кэмп, бетон зуурмагийн үйлдвэрт хуванцар хог хаягдлыг цуглуулах 7 ширхэг савыг байршуулсан.	100%	2

9.1.3	Үйлдвэрийн хаягдал	хог	Үйлдвэрлэлийн гаралтай хаягдлыг ил задгай хаяхгүй байх, зориулалтын битүү саванд ангилан ялгаж, хадгалах дахин ашиглах болон үйлдвэрлэгчид нийлүүлэх	Хог хаягдал цуглуулах савыг хангалттай хэмжээгээр байрлуулсан байна.	“Цогтцэций сумын “Тэгш дүүрэн тохижилт” ОНӨААТҮГ-тай барилгын хог хаягдлын гэрээг байгуулж 8481 тн барилгын хог хаягдлыг сумын нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлж 57.211 сая төгрөгийн төлбөрийг төлсөн. “Элемент” ХХК-тай гэрээ байгуулж 420 кг цементний уутыг устгуулсан. Цогтцэций сумын Эрүүл мэндийн төвтэй эмнэлэгийн хог хаягдлыг устгах гэрээ байгуулж 1.4 кг эмнэлэгийн аюултай хог хаягдлыг устгуулсан.	100%	2
9.1.4	Аюултай хаягдал	хог	Аюултай хог хаягдал үүсгэгч болон аюултай хог хаягдлыг цуглуулах, хадгалах үйл ажиллагааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж, бүртгэлийн дугаар, тусгай зөвшөөрөл авах	Хуулийн дагуу бичиг баримтын бүрдлийг хангасан байна.	Өмнөговь аймгийн БОАЖГ-ын 2019 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 314 тоот албан бичгээр хог хаягдлын үүсгэгчийн бүртгэлийн дугаар авсан.	100%	3
9.1.5			Тусгай зөвшөөрөлтэй ААНБ-тай хог хаягдал нийлүүлэх гэрээ байгуулах	Зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан нийлүүлсэн байна.	“Ханбогд вейст менежмент” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 2.8 тн хаягдал тосыг нийлүүлсэн. “Элемент” ХХК-тай гэрээ байгуулан 540 кг цементний уутыг тушааж устгалд оруулсан. Цогтцэций сумын Эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулж 5.01 кг эмнэлэгийн аюултай хаягдлыг устгуулсан.	100%	2
9.1.6			Химийн хорт болон аюултай бодис ашиглах тусгай зөвшөөрөл авах	Тусгай зөвшөөрийг холбогдох байгууллагаас авсан байна.	“Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам”-д илгээсэн В77-2410-000030 дугаартай “Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах зөвшөөрөл (5,000,001-10,000,000 кг)” хүсэлтээс 2024.10.06 өдөр татгалзсан хариу ирсэн.	100%	3
						100%	15
10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр							

10.1.1	Агаарын чанар	Аэрозол: PM2.5, PM10, нийт тоосонцор	Хагас жил тутамд 3 цэгт хэмжилт хийж гүйцэтгэсэн байна.	Тоосны агууламжийн хэмжилтийг хянах зорилгоор 8533 багажийг ашиглаж Аэрозол: PM2.5, PM10, нийт тоосонцрын хэмжилтийг хийсэн.	100%	1
10.1.2		Хийн төлөвт агаар бохирдуулагчийн шинжилгээ	Хагас жил тутамд 3 цэгт хэмжилт хийж гүйцэтгэсэн байна.	Өмнөговь аймгийн УЦУОШТ-ийн лабораториор гадаад орчны агаарын шинжилгээг 3 цэг /Иргэний барилга, Бетон зуурмагийн үйлдвэр, Үндсэн үйлдвэр/-т 5 сард гүйцэтгүүлсэн.	100%	1
10.1.3		Дуу чимээний хяналт	Хагас жил тутамд 3 цэгт хэмжилт хийж гүйцэтгэсэн байна.	Төсөл хэрэгжих талбайд дуу шуугианы хэмжилтийн хамгийн их утга нь 77.5 дба, дундаж нь 53 дба, хамгийн бага утга нь 39.2 дба байна. Гадаад орчны дуу шуугианы хэмжилтийг 4 сард гүйцэтгэсэн.	100%	1
10.2.1	Хөрсөн бүрхэвч	Хөрсөн дэх хүнд металлын агууламж	Хагас жил тутамд 2 цэгт шинжилгээ хийлгэсэн байна.	НБҮ төслийн Үндсэн үйлдвэр, Бетон зуурмагийн үйлдвэр, Засварын талбай гэсэн 3 цэгээс хөрсний дээж авч Хөрсний итгэмжлэгдсэн лабораторид хөрсний хүнд металлын үзүүлэлтүүдийг шинжлүүлсэн.	100%	1
10.2.2		Агрохими	Хагас жил тутамд 2 цэгт шинжилгээ хийлгэсэн байна.	НБҮ төслийн Үндсэн үйлдвэр, Иргэний барилга, Бетон зуурмагийн үйлдвэр гэсэн 3 цэгээс хөрсний дээж авч Хөрсний итгэмжлэгдсэн лабораторид хөрсний химийн үндсэн үзүүлэлтүүд, механик бүрэлдэхүүнийг шинжлүүлсэн.	100%	1
10.2.3		Нянгийн бохирдол	Хагас жил тутамд 3 цэгт шинжилгээ хийлгэсэн байна.	НБҮ төслийн оффис, кемп, түүхий нүүрсний агуулах гэсэн 3 цэгээс хөрсний дээж авч Хөрсний итгэмжлэгдсэн лабораторид хөрсний нянгийн бохирдлыг шинжлүүлсэн.	100%	1
10.3.1	Усан орчин	Усан дахь эрдэс бодисууд, химийн найрлага	Улирал тутам 4 цэгт шинжилгээ хийлгэсэн байна.	Төслийн үйл ажиллагаанд ашигладаг 2 худгаас усны ерөнхий химийн шинжилгээнд дээж авч, Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн Усны шинжилгээний лаборатори, “Хан лаб” итгэмжлэгдсэн лабораторид 5, 9, 10 саруудад шинжлүүлсэн. Малчны 1 худга /Хадан усны худга/-аас дээж авч 7, 9 саруудад шинжлүүлсэн.	100%	1

10.3.2		Усны хүнд металлын шинжилгээ	Жилд 1 удаа 4 цэгт шинжилгээ хийлгэсэн байна.	Ийрт Плас ХХК-тай байгуулсан ЭТТ-2024/1397 тоот гэрээний дагуу Төслийн үйл ажиллагаанд ашигладаг 2 худаг /НБҮ худаг, ТТЗ худаг/, малчны 1 худаг /Хадан усны худаг/-аас дээж авч шинжлүүлсэн мөн “Хан Лаб” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.	100%	1
10.3.3		Микробиологи	Улирал тутам 4 цэгт шинжилгээ хийлгэсэн байна.	Төслийн үйл ажиллагаанд ашигладаг 2 худаг /НБҮ худаг, ТТЗ худаг/, малчны 1 худаг /Хадан усны худаг/-аас дээж авч Өмнөговь аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн лабораторид шинжлүүлсэн.	100%	1
10.4.1	Ургамлан нөмрөг	Ургамлын мониторинг	Жилд 1 удаа 15 цэгт хийнэ.	Тайлант онд төслийн талбайгаас гадагш салхины зонхилох чиглэл дор 10-15км-ийн зайд ургамлын мониторингийг хийж гүйцэтгэсэн.	100%	0.5
10.5.1	Амьтны аймаг	Амьтны мониторинг	Жилд 1 удаа 4 байрлалд хийнэ.	Нүүрс баяжуулах үйлдвэрийн БОМТ-г хэрэгжүүлэх ЭТТ-2024/1397 тоот гэрээний дагуу “Ийрт Плас” ХХК-ийн биологийн мэргэжилтэнтэй хамтран Цогтцэций сумын Сийрс багийн нутагт байрлах Тугийн цохио, Билгэх багийн нутагт байрлах Хангинахын хаданд амьтны камер байршуулж амьтны суурь судалгааг хийж гүйцэтгэсэн.	100%	0.5
					100%	10
11. Удрдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө						
11.1	БОМТ-ний барьцаа хөрөнгө байршуулах		БОМТ-ний барьцаа хөрөнгийг 100 хувь байршуулсан байна.	БОМТ-ний барьцаа хөрөнгийн 50% буюу 190.842 сая төгрөгийг байгаль орчны тусгай санд байршуулсан.	100%	2
11.2	Тухайн жилийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрх бүхий байгууллагад тайлагнах		БОМТ-ийн биелэлтийн тайланг Өмнөговь аймгийн БОАЖГ-аар дүгнүүлсэн байна.		0%	1
11.3	Жил бүрийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах		БОМТ-г БОАЖЯ-аар батлуулсан байна.	НБҮ-ийн төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-аар батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан.	100%	1


11.4	Байгаль орчны хууль, журам, стандартын хэрэгжилтийг хангах зорилгоор байгаль орчны дотоод хяналтыг хэрэгжүүлэх	Дотоод хяналтын нэгжийн шалгалт хийсэн тайлангаар	Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын журам, Газар хөндөх журам, Өнгөн хөрстэй ажиллах журам, Асгаралтын эсрэг авах арга хэмжээний журам, ХАБЭА, Байгаль орчны зөрчил, зөрчилд авах хариу арга хэмжээний журмуудыг тус тус боловсруулж, батлуулсан. Дэлхийн усны өдрийг тохиолдуулан төслийн инженер, ХАБЭА нарын дунд Байгаль орчны танин мэдэхүйн сургалт орж, АХА тэмцээнийг зохион байгуулж гарын бэлэг гардуулсан. Нийт 40 ажилтан оролцсон.	100%	1
				75%	3.75
